



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 29 (554)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жэгсаалт батлах тухай*
- *Зарим хүмүүсийг сургалтын төрийн сангийн зээл, түүний хүүгийн төлбөрөөс чөлөөлөх тухай*
- *Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарыг хувьчлах, өөрчлөн байгуулах чиглэл батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2008 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2008 оны наймдугаар сарын 7

№29 (554)

Гарчиг

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

461.	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт батлах тухай	Дугаар 175	841
462.	Жагсаалтад нэмэлт оруулах тухай	Дугаар 176	852
463.	Журам батлах тухай	Дугаар 177	852
464.	Зарим хүмүүсийг сургалтын төрийн сангийн эзэл, түүний хүүгийн төлбөрөөс чөлөөлөх тухай	Дугаар 178	860
465.	Хөрөнгө гаргах тухай	Дугаар 180	867
466.	Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарыг хувьчлах, өөрчлөн байгуулах чиглэл батлах тухай	Дугаар 182	867
467.	Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай	Дугаар 183	870
468.	Чиглэл батлах тухай	Дугаар 184	882
469.	Комиссын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 185	883
470.	Төрийн чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай	Дугаар 186	884
471.	Ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 187	884
472.	Ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 203	884

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 175

Улаанбаатар хот

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт батлах тухай

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Жагсаалт шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 1998 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 235 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын дурсгалын хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Н.Болормаа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД

Н.БОЛОРМАА

Засгийн газрын 2008 оны 175 дугаар
тогтоолын хавсралт

УЛС, АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХАМГААЛАЛТАД БАЙХ ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ЖАГСААЛТ

1. Архангай аймаг

Улсын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Батцэнгэл сумын Цацын дэнжийн буган чулуун хөшөө, булш, хиргисүүрийн цогцолбор дурсгал
2. Батцэнгэл сумын Худагийн толгойн Хүннүгийн үеийн булшнууд
3. Ихтамир сумын Алтан сандал уулын орчмын хүн чулуун хөшөө, буган чулуун хөшөө, дөрвөлжин булш, хиргисүүр бүхий цогцолбор дурсгал
4. Ихтамир сумын нутагт орших эртний бичээст Тайхар чулуу
5. Өндөр-Улаан сумын Балгасан талын Хүннүгийн язгууртны оршуулгын газар
6. Хайрхан сумын Гол мод гэдэг газар орших Хүннүгийн язгууртны булш
7. Хашаат сумын Хөшөө цайдам гэдэг газар орших Түрэгийн үеийн Культегин, Билгэ хааны бичигт хөшөө, онгон
8. Хотонт сумын нутагт орших Дойтын толгойн туурь
9. Хотонт сумын Баянголын аманд орших Дөрвөлжингүүд гэдэг бунхант булшнууд
10. Хотонт сумын нутагт орших Уйгарын Хар балгас, түүний бичээст хөшөөний үлдэгдэл хэсгүүд
11. Чулуут, Тариат, Жаргалант, Цэцэрлэг сумдын нутагт орших Чулуут голын хавцлын хадны зураг
12. Эрдэнэбулган сумын төвд орших Заяын гэгээний хийд, чонон хөшөө
13. Эрдэнэмандал сумын нутагт орших Хархул хааны балгас
14. Эрдэнэмандал сумын Баруун цүүр гэдэг газар орших буган чулуун хөшөө

Аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Батцэнгэл сумын төвд орших Луу гүний хүрээний дуганууд
2. Батцэнгэл сумын Шивэртийн аманд орших буган чулуун хөшөө, дөрвөлжин булшнууд
3. Ихтамир сумын Баянцагаан гэдэг газар орших буган чулуун хөшөөнүүд
4. Өгийнуур сумын нутагт орших Өгийнуурын балгас

5. Өлзийт сумын төвд орших Бишрэлт гүний хүрээний дуганууд
6. Өлзийт сумын Хөшөөтийн дэнж гэдэг газар орших буган чулуун хөшөө
7. Өлзийт сумын Бадэгт гэдэг газар орших Олзотын балгас
8. Өлзийт сумын Бадэгт гэдэг газар орших Хөх чулууны хярын хадны зураг
9. Өндөр-Улаан сумын Хэнүй голын хөндийн хиргисүүр, буган чулуун хөшөө бүхий цогцолбор дурсгал
10. Өндөр-Улаан сумын Чулуут голын бэлчирт орших буган чулуун хөшөө
11. Тариат сумын Хөдөө нуурын хойд тал Дадлаг гэдэг газар орших хүн чулуун хөшөө
12. Хайрхан сумын Маймаа толгой гэдэг газар орших Хүннүгийн үеийн булшнууд
13. Хайрхан сумын Гүнжийн аманд орших буган чулуун хөшөө
14. Хайрхан сумын Уртын аманд орших буган чулуун хөшөө
15. Хайрхан сумын Эмээл толгойн хүн чулуун хөшөө
16. Хашаат сумын Их номгоны Хиргист хоолойн хүн чулуун хөшөө
17. Хашаат сумын Бага Номгоны хөндийн зүүн урд бэлд орших хүн чулуун хөшөөнүүд
18. Хашаат сумын Их Номгон гэдэг газар орших хадны зураг, бичиг
19. Хашаат сумын Урд сэртэн гэдэг газар орших хадны зураг
20. Хотонт сумын төвд орших хүн чулуун бичигт хөшөө, буган чулуун хөшөө бүхий чулуун дурсгалууд
21. Эрдэнэбулган сумын төвд орших Дамдин хувилгааны дуган
22. Эрдэнэбулган сумын Булган уулын бурханы зосон зураг
23. Эрдэнэмандал сумын Их нуурын хойд биед орших Орхон бичээст хашлага чулуу, хүн чулуун хөшөөнүүд
24. Эрдэнэмандал сумын Их Жаргалантын буган чулуун хөшөө, булш, хиргисүүр бүхий цогцолбор дурсгал

2. Баян-Өлгий аймаг

Улсын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Баяннуур сумын Цагаан Хөшөөт гэдэг газар орших хүн чулуун хөшөө
2. Бугат сумын Эрээн Харганатын Түрэг бичээс бүхий хөшөө чулуу
3. Буянт сумын Хөлцөөт гэдэг газар орших хадны зураг
4. Ногооннуур сумын төвд орших хүн чулуун хөшөө
5. Ногооннуур сумын Ямаат Улаан уулын хүн чулуун хөшөө
6. Сагсай сумын Даяннуур орчмын 3 ширхэг хүн чулуун хөшөө
7. Сагсай сумын Шивээт Хайрханы хадны зураг
8. Улаанхус сумын Цагаан салаа буюу Бага Ойгор голын хөндийд орших хадны зураг
9. Улаанхус сумын Хар ямаатын голын хөндийд орших хүн чулуун хөшөө
10. Улаанхус сумын Хар ямаатын голын Пазыркийн булшнууд
11. Цэнгэл сумын Арал толгойн хадны зураг
12. Цэнгэл сумын Билүүт гэдэг газар орших хадны зураг
13. Цэнгэл сумын Даян нуурын эрэг Ху-Уй гэдэг газар орших хүн чулуун хөшөө
14. Цэнгэл сумын Могойтын рашаан орчмын хүн чулуун хөшөө
15. Цэнгэл сумын Цагаан голын хөндийд орших буган чулуун хөшөө, булш, хиргисүүрийн цогцолбор дурсгал
16. Цэнгэл сумын Шивээт Хайрханы хадны зураг

Аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Алтай сумын Тошингийн аманд орших хиргисүүрүүд
2. Алтай сумын төвд орших 4 ширхэг хүн чулуун хөшөө
3. Алтай сумын Хаан ширээ гэдэг газар орших хүн чулуун хөшөө, хадны зураг, руни бичгийн дурсгал
4. Алтанцөгц сумын Алаг үзүүр гэдэг газар орших 6 ширхэг хүн чулуун хөшөө
5. Баяннуур сумын Хайртын голын Улаан Хөшөөт гэдэг газар орших хүн чулуун хөшөө
6. Баяннуур сумын Олоннуурын Алаг толгой гэдэг газар орших хүн чулуун хөшөө
7. Дэлүүн сумын Ганц модны голын буган чулуун хөшөөнүүд

8. Ногооннуур сумын Ховд голын хөндий дэх хиргисүүрүүд
9. Сагсай сумын Битүү гэдэг газар орших хүн чулуун хөшөө
10. Улаанхус сумын Согоогийн голын 5 ширхэг хүн чулуун хөшөө
11. Улаанхус сумын Ганц модны бүлэг гэдэг газар орших Түрэгтийн үеийн дурсгал
12. Цэнгэл сумын Мянган хонхор гэдэг газар орших буган чулуун хөшөө
13. Цэнгэл сумын Хадан сэргээл уулын буган чулуун хөшөө, хиргисүүр

3. Баянхонгор аймаг

Улсын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Баянлиг сумын Цахир ууланд орших Лигийн Цагаан агуйн дурсгал
2. Баянлиг сумын Их баян уулын Бичигтийн амны хадны зураг
3. Баянлиг сумын Зоог Зуухын уулын шинэ чулуун зэвсгийн үеийн бууц
4. Бөмбөгөр сумын Арцат дэл уулын хадны оршуулга
5. Бууцагаан сумын Дундмандал, Адагмандал ууланд орших хадны зураг, руни бичгийн дурсгал
6. Галуут сумын нутагт орших Чин сүжигт Номун хааны хийд, түүний орчмын хаданд сийлсэн бурхадны зураг, төвд, монгол бичээс
7. Өлзийт сумын Замын Хашаат гэдэг газар орших хадны зураг
8. Өлзийт сумын Их Булган уулын чулуун зэвсгийн суурин, хиргисүүрүүд
9. Өлзийт сумын Уран хайрхан ууланд орших чулуун зэвсгийн үеийн бууц
10. Эрдэнэцогт сумын Шатар чулуу гэдэг газар орших буган чулуун хөшөө, хүн чулуун хөшөө, булш бүхий цогцолбор дурсгал

Аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Баян-Овоо сумын Дуурсахын хөндийд орших эртний булш, хиргисүүрүүд
2. Баян-Өндөр сумын Чихэн ууланд орших Чихэнгийн агуй
3. Жинст сумын Ногоон цавьна палеонтологийн дурсгалт газар
4. Заг сумын Загийн голын баруун талд орших Бумбатын амны хүн чулуун хөшөөнүүд
5. Заг сумын Алмаст хэвцэл гэдэг газар орших суварга

6. Заг сумын Ар сайр гэдэг газар орших хиргисүүрүүд
7. Заг сумын Хэргэстэйн аманд орших буган чулуун хөшөө
8. Өлзийт сумын нутагт орших Түйн балгас
9. Эрдэнэцогт сумын төвд орших Хачин ламын сүм
10. Эрдэнэцогт сумын Тамчийн Их цагааны аманд орших буган чулуун хөшөө

4. Булган аймаг

Улсын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Баян-Агт сумын Шивээт-Улаан гэдэг газар орших Түрэгийн үеийн цогцолбор дурсгал
2. Дашинчилэн сумын Халдунзүрх ууланд орших Цогтын Цагаан байшингийн балгас, гэрэлт хөшөө
3. Дашинчилэн сумын нутагт орших Харбухын балгас
4. Дашинчилэн сумын нутагт орших Чин толгойн балгас
5. Могод сумын Хөл Асгат гэдэг газар орших Түрэгийн Алтан тамгат дархны бичигт хөшөө
6. Сайхан сумын Байширын ус гэдэг газар орших буган чулуун хөшөө
7. Сайхан сумын Хиргист хөндийн аманд орших Уйгарын Могоунчурын гэрэлт хөшөө
8. Сэлэнгэ сумын Ингэт толгойд орших "Далхабандида" гэдэг хүн чулуун хөшөө
9. Хутаг-Өндөр сумын нутагт орших Бийбулагийн балгас
10. Хутаг-Өндөр сумын Төлбөрийн голын сав дагуух чулуун зэвсгийн суурин, эртний булш, хиргисүүрүүд

Аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Баян-Агт сумын Халтар гэдэг газар орших буган чулуун хөшөөнүүд
2. Бугат сумын Хужиртын голын хөндийд орших Бичигтийн хадны зураг, бичээс
3. Булган сумын Майдарын голын хөндийд орших Цагаан суварга
4. Булган сумын Зүүн түрүү гэдэг газар орших хүн чулуун хөшөө
5. Булган сумын төвд орших Диваажингийн сүмийн туурь
6. Бүрэгхангай сумын Бичигтийн хадны хошуунд орших хадны бичиг
7. Гурванбулаг сумын Авзага хайрхан ууланд орших хадны зураг
8. Гурванбулаг сумын Гурвалжин уулын түрэг бичээс

9. Дашинчилэн сумын Лах уул, Арслант гэдэг газар орших хадны зураг
10. Дашинчилэн сумын Бүдүүний нурууны Хангидай гэдэг газар орших хадны зураг
11. Могод сумын Цахиуртай гэдэг газар орших буган чулуун хөшөө
12. Могод сумын Улаан хаалга гэдэг газар орших хадны зураг
13. Орхон сумын Сээрийн адаг гэдэг газар орших 7 ширхэг буган чулуун хөшөө
14. Рашаант сумын Хөгнө хан ууланд орших Хөгнө ханы их, бага хийдийн туурь
15. Сайхан сумын Нарийн хүрмийн Хөшөөн дэвсэг гэдэг газар орших хүн чулуун хөшөө
16. Сайхан сумын Их Хүрэмтийн Асган дэвсэг гэдэг газар орших буган чулуун хөшөө
17. Сайхан сумын Нарийн Хүрэмт гэдэг газар орших хадны бичээс
18. Тэшиг сумын хуучин төвд орших буган чулуун хөшөө
19. Хишиг-Өндөр сумын төвийн хойд талд орших буган чулуун хөшөө
20. Хишиг-Өндөр сумын Ар ханан гэдэг газар орших түрэг бичээс
21. Хутаг-Өндөр сумын Нарийн төлбөрийн Бичигт бэржин гэдэг газар орших хадны бичээс
22. Хутаг-Өндөр сумын Нарийн төлбөрийн адаг гэдэг газар орших буган чулуун хөшөө
23. Хутаг-Өндөр сумын Гуртын гүүр, Усны арал гэдэг газар орших хүн чулуун хөшөө
24. Хутаг-Өндөр сумын Бичигтийн үзүүр гэдэг газар орших хадны зураг
25. Хутаг-Өндөр сумын Эгийн голын хөндий дэх олон үеийн цогцолбор дурсгал

5. Говь-Алтай аймаг

Улсын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Алтай сумын Шар тээгийн палеонтологийн дурсгалт газар
2. Бигар сумын Бичигтийн бууц гэдэг газар орших хадны зураг, түрэг бичээс
3. Дарви сумын Гурван эрээний нуур орчмын палеонтологийн дурсгалт газар
4. Жаргалан сумын Сүмийн дэнж гэдэг газар орших 4 ширхэг хүн чулуун хөшөө, эртний булшнууд
5. Жаргалан сумын Тоосгот гэдэг газар орших хүн чулуун хөшөө
6. Тонхил сумын Урд Хулдын Шататын бэлчирт орших хөшөө чулуу, хүн чулуун хөшөө, дөрвөлжин булш бүхий цогцолбор дурсгал

7. Халиун сумын Цагаан гол гэдэг газар орших хадны зураг, тамга тэмдэг
8. Цогт сумын төвийн дэргэд орших Хиргист хоолойн булшнууд

Аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Алтай сумын Их Отроого гэдэг газар орших 2 ширхэг чулуун хөшөө
2. Баян-Уул сумын Их номгон гэдэг газар орших хадны зураг
3. Баян-Уул сумын Бичигтийн аманд орших хөшөө чулуу бүхий дөрвөлжин булш
4. Баян-Уул сумын Бага бэрх, Доогийн бууц гэдэг газар орших хадны зураг
5. Баян-Уул сумын Доогийн ханангийн бууц гэдэг газар орших хадны зураг
6. Бигэр сумын Морин толгой гэдэг газар орших хадны зураг, дөрвөлжин булш
7. Бугат сумын Тамчийн бэлчир гэдэг газар орших хүн болон буган чулуун хөшөө бүхий 3 ширхэг булш
8. Бугат сумын Дүүргийн ам гэдэг газар орших буган чулуун хөшөө
9. Бугат сумын Бургасын гүрээ гэдэг газар орших буган чулуун хөшөө бүхий хиргисүүр, дөрвөлжин булш
10. Бугат сумын Хөшөөтийн эх гэдэг газар орших буган чулуун хөшөө
11. Жаргалант сумын Улаан хайрхан гэдэг газар орших хадны зураг, бичээс
12. Тайшир сумын нутагт орших Наробанчин хийдийн туурь
13. Тайшир сумын Өвөр цагаан толгой гэдэг газар орших гэрэлт хөшөө
14. Тонхил сумын Хөшөөт бэлчир гэдэг газар орших буган чулуун хөшөө
15. Тонхил сумын Хяр хараач гэдэг газар орших хөшөө чулуу бүхий булшнууд
16. Тонхил сумын Бага ус гэдэг газар орших хүн ба буган чулуун хөшөө бүхий 3 ширхэг булш
17. Тонхил сумын Могойн голын хөндийд орших Хүрлийн үеийн чулуун хөшөөнүүд
18. Тонхил сумын Тамчийн талд орших буган чулуун хөшөө
19. Тонхил сумын Хужирын голын хөндийн Хөх денгө гэдэг газар орших хүн чулуун хөшөө, дөрвөлжин булш бүхий цогцолбор дурсгал
20. Тонхил сумын Зүйлийн Отроого гэдэг газар орших хүн чулуун хөшөө
21. Хөхморьт сумын Бургасын дэнж гэдэг газар орших хөшөө чулуу бүхий дөрвөлжин булш
22. Хөхморьт сумын Замын гозгор гэдэг газар орших хөшөө чулуу, дөрвөлжин булш

23. Цогт сумын Найтааст гэдэг газар орших хадны зураг
24. Чандмань сумын Шаахар толгойн хадны зураг
25. Чандмань сумын төвийн орчимд орших чулуун хөшөөнүүдтэй дөрвөлжин булш
26. Чандмань сумын Чандмань ууланд орших овоо бунхан
27. Эрдэнэ сумын Дэвэрхийн эх гэдэг газар орших хөшөө чулуу
28. Эрдэнэ сумын Нарийнголын хөндийд орших Нарангийн бичигт хөшөө чулуу
29. Эрдэнэ сумын Улаан толгой гэдэг газар орших хөшөө чулуу

6. Говьсүмбэр аймаг

Аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Сүмбэр сумын нутагт орших Чойрын хийдийн туурь
2. Сүмбэр сумын Зараагийн зүүн өвөрт орших хүн чулуун хөшөө, булш

7. Дархан-Уул аймаг

Улсын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Орхон сумын Цант гэдэг газар орших эртний хотын туурь
2. Хонгор сумын Буурал ууланд орших эртний булшнууд
3. Орхон сумын Хүйтэний голын хадны зосон зураг, бичээс

Аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Орхон сумын Шарын голын хөндий Цагааннуурын хойно орших хадны зосон зураг
2. Хонгор сумын Хонгор гэдэг газар орших хадны зураг, бичээс

8. Дорноговь аймаг

Улсын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Дэлгэрэх сумын Чандмань хар ууланд орших шинэ чулуун зэвсгийн үеийн суурин, эртний булшнууд
2. Иххэт сумын Бүсийн чулуу гэдэг газар орших Олон байшинт, Хэсэг байшинт гэдэг эртний хотын туурь
3. Иххэт сумын Хөшөөн ухаа гэдэг газар орших хөшөө чулуу бүхий булш, туурь
4. Мандах сумын Сүйхэнт уулын палеонтологийн дурсгалт газар

- Хатанбулаг сумын Эргилийн зоон палеонтологийн дурсгалт газар

Аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

- Зүүнбаян суманд орших Хонгил цав, Бурхантын палеонтологийн дурсгалт газар
- Иххэт сумын Ар-Улаан гэдэг газар орших хүн чулуун хөшөө
- Мандах сумын Хүрэл, Үнэгт гэдэг газар орших ашигт малтмал олборлож байсан ором, зуух
- Сайхандулаан сумын Хар хөтөл, Шинэ ус худгийн палеонтологийн дурсгалт газар
- Улаанбадрах сумын Хоёр зааны палеонтологийн дурсгалт газар
- Хөвсгөл сумын Баянгийн ширээ, Гуа тээгийн палеонтологийн дурсгалт газар
- Хөвсгөл сумын нутагт орших Цувиррагийн хийдийн туурь
- Эрдэнэ сумын Дулааны говь гэдэг газар орших чулуун зэвсгийн үеийн суурин

9. Дорнод аймаг

Улсын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

- Сүмбэр сумын нутагт орших "Их бурхант" чулуун бурханы цогцолбор дурсгал
- Сүмбэр сумын Шонх таван толгой гэдэг газар орших хүн чулуун хөшөө
- Цагаан-Овоо сумын нутагт орших Хэрлэн барс хотын туурь, цамхаг

Аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

- Булган сумын нутагт орших Чингисийн хар тугийн сүмийн туурь
- Гурванзагал, Дашбалбар, Баяндун, Баян-Уул сумдын нутагт орших Чингисийн хэрмэн зам
- Матад сумын Наран гэдэг газар орших хүн чулуун хөшөө
- Матад сумын Ловохын овоо гэдэг газар орших хүн чулуун хөшөө
- Матад сумын Барчигар, Буян-Өндөр гэдэг газар орших хүн чулуун хөшөөнүүд
- Сүмбэр сумын Тамсагбулаг гэдэг газар орших Утай уул, сүмийн туурь
- Сүмбэр сумын хуучин Тамсагбулаг сумын төвийн зүүн талд орших чулуун зэвсгийн үеийн суурин
- Цагаан-Овоо сумын Зүүн дөрөө гэдэг газар орших эртний хотын туурь

10. Дундговь аймаг

Улсын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

- Адаацаг сумын нутагт орших Сүм Хөхбүрдийн балгас

- Баянжаргалан сумын Хүрэн духын палеонтологийн дурсгалт газар
- Гурвансайхан сумын Ярх ууланд орших хуучин чулуун зэвсгийн үеийн бууц
- Өлзийт сумын Баруун билүүт ууланд орших хадны зураг, түрэг бичээс
- Өлзийт сумын Дэл булчин Хамар ус, Гучин хоёр хүн хөшөөт гэдэг газар орших хадны зураг, буган чулуун хөшөө цогцолбор дурсгал
- Эрдэнэдалай сумын төвд орших Угтаал Сангийн далай хийдийн Цогчин дуган
- Эрдэнэдалай сумын Цагаан-Овоо гэдэг газар орших Үнстийн хийдийн Цогчин дуган

Аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

- Адаацаг сумын нутагт орших Зуутын хийдийн 2 ширхэг дуган
- Баянжаргалан сумын Аргын хадны Саруулын бичигт хад гэдэг газар орших хадны бичээс
- Баянжаргалан сумын Баянхошууны Эмээл толгойд орших хэрмийн үлдэгдэл
- Говь-Угтаал сумын Их газрын чулууны ард орших хадны бичээс
- Дэлгэрхангай сумын Онгийн голын эрэгт орших Хошуу хийдийн туурь
- Дэлгэрхангай сумын Хархашаатын аманд орших хадны зураг
- Дэлгэрцогт сумын Бага газар орших Хүннүгийн үеийн булшнууд
- Дэлгэрцогт сумын Бага газрын чулууны өвөр бэл Их тахилгатын хадны зураг
- Дэлгэрцогт сумын Седетийн амны эхний хадны зураг
- Луус сумын Улааннуурын ард орших Хөшөөт гэдэг газрын хөшөө чулуу
- Өндөршил сумын Нартын хадны Мухарын булаг гэдэг газар орших чулуун зэвсгийн үеийн дархны газар
- Сайхан-Овоо сумын Онгийн голын эрэгт орших Онгийн хийдийн туурь
- Сайхан-Овоо сумын Онгийн голын эрэгт орших Шаазан хотын туурь
- Хулд сумын Шарангадын нүхэн гэдэг газар орших монгол, төвд бичигтэй агуй
- Цагаандэлгэр сумын Шар шороотын бууцны орчимд орших хөшөө чулуу
- Эрдэнэдалай сумын Өргөн гэдэг газар орших "Суудал хад" гэдэг дөрвөлжин булш

11. Завхан аймаг

Улсын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

- Алдархаан сумын Богдын голын Мөнгөт хясаа гэдэг газар орших 4 хүний зураг бүхий чулуун хөшөө
- Баянтэс сумын Хөх хошууны боомын булшнууд

3. Цэцэн-Уул сумын Янживын шилд орших хүн чулуун хөшөөнүүд
4. Шилүүстэй сумын Дааган дэл гэдэг газар орших 8 ширхэг буган чулуун хөшөө
5. Яруу сумын Яруугийн голын эрэгт орших хүн чулуун хөшөөнүүд
6. Яруу сумын нутагт орших Хөшөөтийн амны хүн чулуун хөшөө

Аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Дөрвөлжин сумын Баян-Айрагийн хадны зураг
2. Тэлмэн сумын Дунд шургахын амны эхэнд орших буган чулуун хөшөө, хиргисүүрийн цогцолбор дурсгал
3. Улиастай сумын төвд орших Сангийн хэрмийн туурь
4. Эрдэнэхайрхан сумын Харнуурын зүүн тал Тээлийн хөндийд орших 2 ширхэг хүн чулуун хөшөө
5. Эрдэнэхайрхан сумын Бага хөлийн бууцны ард орших хадны зураг

12. Орхон аймаг

Аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Жаргалант сумын Чингэлийн голын сав дагуух эртний булш, хиргисүүрүүд

13. Өвөрхангай аймаг

Улсын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Баруунбаян-Улаан сумын Андай сайр, Шанд гол, Таацын гол, Татал голын палеонтологийн дурсгалт газрууд
2. Бат-Өлзийт сумын Нарийны аманд орших Төвхөн хийд
3. Гучин-Ус сумын Өөшийн нуруу, Хөөвөрийн палеонтологийн дурсгалт газар
4. Уянга сумын Онгийн голын цогцолбор дурсгал
5. Хайрхандулаан сумын Хөгшинтээл ууланд орших Хубилайн цэргийн цайзны туурь
6. Хархорин сумын Мойлтын ам гэдэг газар орших хуучин чулуун зэвсгийн үеийн бууц
7. Хархорин сумын төвд орших Монголын эзэнт гүрний нийслэл Хархорум хотын туурь, түүний орчим дахь 2 ширхэг чулуун яст мэлхий
8. Хархорин сумын төвд орших Эрдэнэ зуу хийд
9. Хархорин сумын төвд орших Г.Занабазарын эх Ханджамцын суварга

Аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Арвайхээр сумын төвд орших Буга согоотын хадны зураг

2. Баруунбаян-Улаан сумын Хүнхэрээ гэдэг газар орших Шаазан толгойн туурь
3. Баруунбаян-Улаан сумын Таримлын өвөлжөөний урд орших хүн чулуун хөшөө
4. Баруунбаян-Улаан сумын Өшгөгийн нуруунд орших Харын бумбат, Барчин тээгийн хадны зургууд
5. Бат-Өлзийт сумын Тэмээн чулууны аманд орших буган чулуун хөшөө, булшнууд
6. Бат-Өлзийт сумын Өндөр хясаа гэдэг газар орших буган чулуун хөшөө
7. Бат-Өлзийт сумын Өвөр агуйт гэдэг газар орших хиргисүүр
8. Бат-Өлзийт сумын Ар агуйтын хөшөөн хонхорт орших хөшөө
9. Баян-Өндөр сумын Зүйлийн хөндийд орших Бууралын хүн чулуун хөшөө
10. Богд сумын Тэвш ууланд орших хадны зураг
11. Богд сумын нутагт орших Илжэн чихт хааны хэрмийн туурь
12. Богд сумын Арц Богд уулын зүүн үзүүр Мухар булаг гэдэг газар орших чулуун зэвсгийн суурин
13. Нарийнтээл сумын нутагт орших Ламын гэгээний суварга
14. Нарийнтээл сумын нутагт Арцат гэдэг газар орших эрдэмтэн Цэвэллаанчигдоржийн суварга
15. Уянга сумын Хадан хошуун гэдэг газар орших хүн чулуун хөшөө
16. Уянга сумын нутагт орших Мааньтын хөшөө
17. Хархорин сумын нутагт орших Шанхын хийдийн дуганууд
18. Хархорин сумын урд Мэлхий толгой дээр орших барилгын туурь, чулуун яст мэлхий
19. Хархорин сумын урд Мэлхий толгойн бэлд орших эрхтэн чулуун хөшөө
20. Хархорин сумын Бага хүрээ гэдэг газар орших дутуу хийсэн чулуун яст мэлхий
21. Хархорин сумын нутагт орших Их элстийн дэнжийн хөшөө
22. Хархорин сумын нутагт Саран голын баруун эрэгт орших Хар чулууны хүн чулуун хөшөө
23. Хархорин сумын Хөшөөн дэнж, Саран голын эрэгт орших хүн чулуун хөшөө
24. Хархорин сумын Зараа толгой гэдэг газар орших хадны зураг, бичээс
25. Хархорин сумын Гүмбийн дэнжид орших буган чулуун хөшөө
26. Хужирт сумын Шунхлай ууланд орших дөрвөлжин булшнууд

14. Өмнөговь аймаг

Улсын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Булган сумын Баянзаг, Төгрөгийн ширээ, Авдрант, Алаг тээгийн палеонтологийн дурсгалт газар

2. Булган сумын Цахиуртын хөндийд орших Чулуун зэвсгийн үеийн дархны газар
3. Гурвантэс сумын Хэрмийн цэв, Цагаан хошуу, Бүгийн цав, Гурилын цав, Алтан-Уул, Нэмэгт, Ухаа толгодын палеонтологийн дурсгалт газар
4. Номгон сумын Шүүлэн, Долоон-Уулын өвөр Бичигт гэдэг газар орших хадны зураг
5. Ханбогд сумын нутагт орших Байшин цав, Хуурай цав, Үрэлбэ, Амтгайн палеонтологийн дурсгалт газрууд
6. Ханбогд сумын нутагт орших Галбын гурван хийд буку Дэмчигийн хийд, Эрээт хийд, Цогцолын хийдийн туурь
7. Ханбогд сумын Жавхланта Хайрхан, Далайн дуулга, Зүүн хацавч, Цагаан толгой, Шийрийн хадны зурагнууд
8. Цогт-Овоо сумын Алгүй-Улаан цавын палеонтологийн дурсгалт газар

Аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Булган сумын Баянзаг гэдэг газар орших хуучин чулуун зэвсгийн үеийн бууц
2. Гурвантэс сумын Хайчин уул, Наранбулагийн палеонтологийн дурсгалт газрууд
3. Гурвантэс сумын Баян толгой, Шивээт толгойн бунхант булшнууд
4. Гурвантэс сумын Овоо-Ус гэдэг газар орших хиргисүүр
5. Манлай сумын Хармагтайн ашигт малтмал олборлож байсан ором
6. Манлай сумын Шар цав, Могойн дэл уулын палеонтологийн дурсгалт газар
7. Номгон сумын Цагаан дэрст гэдэг газар орших Бичигтийн усан дахь хадны зураг
8. Номгон сумын Уртын амралт гэдэг газар орших хадны зураг, хүн чулуун хөшөө
9. Номгон сумын төвд орших Сангийн далай хийдийн дуганууд
10. Номгон сумын Далан-Уулын өмнө биед орших Түрэг бичээс
11. Ноён сумын Ихэр гашуун гэдэг газар орших хадны зураг
12. Ханбогд сумын "Мангасын хүрээ" гэдэг эртний туурь
13. Хүрмэн сумын Бичигт гэдэг газар орших хадны зураг
14. Сэврэй сумын нутаг Сэврэй уулын баруун үзүүр, Хар дэлийн бууц гэдэг газар орших хадны зураг
15. Сэврэй сумын Арц богд уулын Хонгил, Үүдэн сайр, Замын хонд, Ягаан ховилын палеонтологийн дурсгалт газар

15. Сүхбаатар аймаг

Улсын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Дарьганга сумын төвд орших Алтан-Овооны хүн чулуун хөшөөнүүд

2. Дарьганга сумын Ламт гэдэг газар орших хүн чулуун хөшөөнүүд
3. Дарьганга сумын Хөргийн хөндийн хүн чулуун хөшөөнүүд
4. Мөнххаан сумын Устай бургастай гэдэг газар орших шинэ чулуун зэвсгийн үеийн бууц
5. Наран сумын Зүлэгт гэдэг газар орших Сөдөтийн цагаан чулууны бичээс
6. Онгон сумын Тавантолгой гэдэг газар орших 2 ширхэг хүн чулуун хөшөө, булш, хиргисүүр бүхий цогцолбор дурсгал
7. Онгон сумын Шивээт гэдэг газар орших хүн чулуун хөшөөнүүд
8. Түвшинширээ сумын Дэлгэрхаан ууланд орших Цагаан-Элэгийн хадны зураг, Хүнцүгийн үеийн 200 гаруй булш, чулуун хороо, шивээ бүхий цогцолбор дурсгал

Аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Дарьганга сумын нутагт орших Хөхөлийн ширээний хүн чулуун хөшөөнүүд
2. Дарьганга сумын Сүмт гэдэг газар орших эртний хотын туурь
3. Онгон сумын Бударын чулуу гэдэг газар орших хадны зураг
4. Эрдэнэцагаан сумын нутагт орших Халтарын хийдийн балгас

16. Сэлэнгэ аймаг

Улсын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Алтанбулаг сумын төвд орших Ардын намын Төв хороо, Түр Засгийн газар байрлаж байсан байшин
2. Баруунбүрэн сумын Бүрэнхан уулын өвөрт орших Амарбаясгалант хийд

Аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Алтанбулаг сумын төвд орших Ардын хувьсгалын түүхэнд холбогдох барилга байшингууд
2. Ерөө сумын нутагт Хүдэррийн голын Хүдэр харуул гэдэг газарт орших буган чулуун хөшөө
3. Ерөө сумын Алтан овооны дэргэдэх буган чулуун хөшөө, дөрвөлжин булш, хиргисүүр бүхий цогцолбор дурсгал
4. Ерөө сумын Төмөртэйн ашигт малтмал олборлож байсан эртний зуухууд
5. Түшиг сумын Тавтын тал гэдэг газар орших олон үеийн булшнууд

17. Төв аймаг

Улсын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Алтанбулаг сумын Өнгөт уулын үрд хөндийд орших түргийн үеийн хашлагаг

- булш, хүн чулуун болон амьтны дүрст чулуун хөшөө бүхий цогцолбор дурсгал
2. Алтанбулаг сумын нутагт орших Морин толгойн олон үед холбогдох булшнууд
3. Батсүмбэр сумын Хараагийн Ноён ууланд орших Хүннүгийн үеийн булшнууд
4. Баянжаргалан сумын нутагт орших Гуа дов гэдэг эртний хотын туурь
5. Баянцагаан сумын Гашуун балгастай гэдэг газар орших Түрэгийн гэрэлт хөшөө
6. Баянцагаан сумын Хүүхэн хонгор гэдэг газар орших 2 ширхэг хүн чулуун хөшөө
7. Борнуур сумын нутагт орших Хүннүгийн үеийн Бороогийн суурин
8. Дэлгэрхаан сумын нутаг Дуутын хар чулуу гэдэг газар орших Цогттайжийн яруу найргийг сийлж бичсэн хад
9. Дэлгэрхаан сумын Их хөшөөт гэдэг газар орших Түрэгийн Кул-Үүрын гэрэлт хөшөө бүхий цогцолбор дурсгал
10. Зуунмод сумын Зуунмодны аманд орших Манзуширын хийдийн туурь, түүний орчмын хаданд сийлсэн бурхадын зураг
11. Мөнгөнморьт сумын нутагт орших "Тэрэлжийн дөрвөлжин" гэдэг эртний хотын туурь
12. Мөнгөнморьт сумын нутагт орших "Бүрхийн дөрвөлжин" гэдэг эртний хотын туурь
13. Өндөрширээт сумын Уянгын үзүүр гэдэг газар орших хадны зураг
14. Эрдэнэ сумын Ар Жанчивлангийн баруун дэнжид орших Тоньюкукийн гэрэлт хөшөө бүхий цогцолбор дурсгал
15. Эрдэнэ сумын Баруунбаян гэдэг газар орших Гүнжийн сүмийн үлдэгдэл

Аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Баян сумын Өгөөмөр гэдэг газар орших хүн чулуун хөшөө
2. Баян сумын Багахангай, Хангайбулаг гэдэг газар орших хүн чулуун хөшөө
3. Дэлгэрхаан сумын төвд орших Мишиг гүний хүрээний дуганууд
4. Мөнгөнморьт сумын нутагт орших Сарьдагийн хийдийн туурь
5. Мөнгөнморьт сумын Тогос уулын өвөр хажуугаар орших олон үеийн дурсгал
6. Сүмбэр сумын нутаг Загдалын голын хойд болд орших хүн чулуун хөшөөнүүд

18. Увс аймаг

Улсын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Давст сумын Бор нурган гэдэг газар орших 2 ширхэг хүн чулуун хөшөө
2. Зүүнхангай сумын нутагт орших Зураагийн улаан гэдэг газар орших хадны зураг

3. Сагил сумын нутагт орших Можоогийн хадны зураг
4. Сагил сумын Дунд Турагийн хад үзүүр гэдэг газар орших хадны зураг
5. Тарилан сумын Халхайтын дэнж гэдэг газар орших булш, хүн чулуун хөшөөнүүд

Аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Бөхмөрөн сумын Захын-Улаан гэдэг газар орших хөшөө чулуу бүхий булш
2. Давст сумын Хатуугийн Мөнгөтцахиур гэдэг газар орших хадны зураг
3. Завхан сумын нутагт орших Сангийн далай нуурын хотгор, Татаалын палеонтологийн дурсгалт газар
4. Малчин сумын Хөтөл нуурын Бор толгойн хүн чулуун хөшөөнүүд
5. Наранбулаг сумын Жаажаагийн хөтөл гэдэг газар орших хүн чулуун хөшөөнүүд
6. Өмнөговь сумын Шарбулагийн онц гэдэг газар орших хадны зураг
7. Улаангом сумын Чандмань ууланд орших булшнууд
8. Улаангом сумын төвд орших Харлаг бэйсийн сүм

19. Ховд аймаг

Улсын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Манхан сумын Тахилтын хотгор гэдэг газар орших Хүннүгийн язгууртны булш
2. Манхан сумын Хойдцэнхэрийн-Өл гэдэг газар орших Гурванцэнхэрийн агуйн хадны зураг
3. Манхан сумын Ишгэн толгойн хадны зураг
4. Мөнххайрхан сумын Долооннуурын Улаан толгойд орших эртний бичээс
5. Мөст сумын Бодончийн гол, Баянзүрх гэдэг газар орших хиргисүүр, бутан чулуун хөшөөний цогцолбор, чулуун зэвсгийн үеийн бууц
6. Үенч сумын Ямаан-Ус гэдэг газар орших хадны зураг
7. Ховд сумын Сөрт гэдэг газар орших дүрс, тэмдэг бүхий хөшөө чулуу
8. Цэцэг сумын Халиуны хөтөл гэдэг газар орших хүн чулуун хөшөө
9. Эрдэнэбүрэн сумын Цамбагарав уулын Хар дэлийн бууцны хадны зураг

Аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Булган сумын Ягшийн хөдөө гэдэг газар орших эртний булшнууд
2. Жаргалант сумын төвд орших Сангийн хэрмийн туурь
3. Мөнххайрхан сумын Улаан говийн аманд орших хүн чулуун хөшөө

4. Мөнххайрхан сумын Шуурхайн хөх нуурын орчимд орших хүн чулуун хөшөө
5. Мөнххайрхан сумын Доод-Улхан гэдэг газар орших хадны зураг
6. Мөнххайрхан сумын Дээд-Улаан говийн аманд орших буган чулуун хөшөө
7. Уян сумын нутагт орших Харуул-Овоо
8. Ховд сумын Чандмань Хар-Үзүүр гэдэг газар орших хадны зураг

20. Хөвсгөл аймаг

Улсын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Алаг-Эрдэнэ сумын Эрхэлийн Улаантолгой гэдэг газар орших 4 ширхэг буган чулуун хөшөө, хиргисүүрүүд
2. Арбулаг сумын Дэлгэрмөрөний эрэг Алтангадас уулын баруун талд орших Мөнх хааны Эрчүү хотын туурь
3. Бүрэнтогтох сумын Уушгийн өвөр гэдэг газар орших 15 ширхэг буган чулуун хөшөө, хиргисүүр, дөрвөлжин булш бүхий цогцолбор дурсгал
4. Бүрэнтогтох сумын Сөртний хөндий гэдэг газар орших буган чулуун хөшөөнүүд
5. Галт сумын Бартад бригадын дэргэд орших 6 ширхэг буган чулуун хөшөө, хиргисүүр бүхий цогцолбор дурсгал
6. Төмөрбулаг сумын Зуны голын орчимд орших буган чулуун хөшөө, хиргисүүр бүхий цогцолбор дурсгал
7. Цагаан-Уул сумын Бор хужирын голын орчимд орших 2 эгнээ буган чулуун хөшөө
8. Цагаан-Уул сумын Хөшөөт гэдэг газар орших 11 ширхэг буган чулуун хөшөө, хиргисүүр
9. Шинэ-Идэр сумын Цохиотын голын бэлчир Дөрөлжийн ам, Цохиотын хөндийн Ногоон булагийн ам гэдэг газар орших буган чулуун хөшөөнүүд

Аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Арбулаг сумын Дэлгэрхаан уулын өвөр, Мөрөнгийн голын эрэгт орших хадны зураг
2. Арбулаг сумын Чавганцын Улаан уул, Салхитын хар хад, Баян-Үзүүр гэдэг газар орших хиргисүүрүүд
3. Арбулаг сумын "Чингүнжавын гэрийн буурь" гэдэг эртний булш
4. Баянзүрх сумын Бичигт булангийн Монгорцог, Хөнгөрцөг хадны зосон зураг
5. Бүрэнтогтох сумын Мөрөнгийн голын хөндийд орших хадны зураг
6. Галт сумын нутаг Хужиртын хүрээний дэргэд байгаа чулуун суварга
7. Галт сумын Чулуут голын Их хужиртын ам, Доод хужиртын ам гэдэг газруудад орших хадны зураг

8. Галт сумын Нүхтийн ам гэдэг газар орших буган чулуун хөшөө, булшнууд
9. Галт сумын Өндөр толгойд орших хадны зураг
10. Галт сумын Улаанчулууны хад гэдэг газар орших хадны зураг
11. Жаргалант сумын нутагт орших Гэлэнхүүгийн суварга
12. Жаргалант сумын Агьтны голын баруун салаанд орших хадны зураг
13. Жаргалант сумын нутагт орших Жаргалантын дуган
14. Ренчинлхүмбэ сумын Тэхийн өвөрт орших Хосын үзүүрийн тамгатай хөшөө чулуу
15. Тариалан сумын Зүлэгт голын савд орших Түрэгийн үеийн хөшөө
16. Тариалан сумын Зүлэгтийн голын зүүн хөвөөнд орших хадны бичээс
17. Улаан-Уул сумын Толжгий боомт гэдэг газар орших хадны зураг
18. Ханх сумын Жаргалантын ам гэдэг газар орших хадны зураг
19. Цагааннуур сумын Шишгид голд цутгасан Харанга ой голын дээд ам, Хээргийн боом гэдэг хясааны дээд талд, доод Тощдог уулын ард талд Оржук хаданд байгаа түрэг бичиг
20. Цэцэрлэг сумын Шаварын нурууны баруун тал Жаргалантын аманд орших ноёдын булхан
21. Цэцэрлэг сумын Тэсийн голын урд хөндий Модтой толгойн хадны зураг
22. Цэцэрлэг сумын Бага харганатын амны Зуррагт хад гэдэг газар орших хадны зураг
23. Чандмань-Өндөр сумын Бадарын нурууны Чадиртын амны буган чулуун хөшөө
24. Чандмань-Өндөр сумын Булжихан голын 3 ширхэг буган чулуун хөшөө
25. Шинэ-Идэр сумын нутагт орших хадны зураг
26. Эрдэнэбулган сумын нутагт орших Даян дээрхийн агуй, хийдийн туурь

21. Хэнтий аймаг

Улсын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Батширээт сумын нутагт орших "Рашаан" хад, Үзүүр цохионы чулуун зэвсгийн бууц хадны зураг, тамга, бичээс, булш, буган чулуун хөшөө бүхий цогцолбор дурсгал
2. Батширээт сумын Өглөгчийн хэрмийн туурь, булш
3. Баян-Адрага сумын Дуурлиг нарс гэдэг газар орших Хүннүгийн язгууртны булш
4. Баянхутаг сумын Сэрвэн халлга гэдэг газар орших хадны бичээс
5. Биндэр сумын Борбулаг гэдэг газар орших Хүннүгийн үеийн булшнууд
6. Дэлгэрхаан сумын Аваргын рашааны арын дэнжид орших Аваргын балгас

7. Дэлгэрхаан сумын нутагт орших Хэрлэнгийн Хөдөө арлын дурсгалууд
8. Дэлгэрхаан сумын Их Хайлант, Шар хад, Ханангийн энгэр гэдэг газар орших олон үеийн булшнууд, чулуун зэвсгийн үеийн бууц
9. Жаргалтхаан сумын Дуулга ууланд орших Хүннүгийн үеийн булшнууд
10. Өмнөдэлгэр сумын Дунд Жаргалант гэдэг газар орших буган чулуун хөшөө, хиргисүүрүүд
11. Өмнөдэлгэр сумын Балдан Бэрээвэн хийд, түүний орчмын хаданд сийлсэн бурхадын зураг
12. Хэрлэн сумын төвд орших Цэцэн ханы ордны цогцолбор
13. Хэрлэн сумын төвд орших "Гэлэн" гэдэг хүн чулуун хөшөө

Аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Батширээт сумын Эгийн Живхээстэйн амны хүн чулуун хөшөө
2. Батширээт сумын Баянголын ам нутагт орших хүн чулуу
3. Батноров сумын Тунсаг овооны хадны зураг
4. Батноров сумын Дүнгэндэг гэдэг газар орших туурай тамга бүхий дурсгал
5. Баянмөнх сумын Дулаан уулын олон үеийн булшнууд
6. Баянхутаг сумын Соно уул, Баянцагааны хүн чулуун хөшөөнүүд
7. Биндэр сумын Асгат ууланд орших чулуун зэвсгийн бууц, дөрвөлжин булшнууд
8. Биндэр сумын Ононгийн Улаан эргийн булшнууд
9. Дархан сумын Хоодойн булгийн дэрсний хүн чулуун хөшөө
10. Дэлгэрхаан сумын Гүнбүрд, Тооно ууланд орших хүн чулуун хөшөө, хиргисүүр, булш бүхий цогцолбор дурсгал
11. Дэлгэрхаан сумын Долоод, Бурхан толгойн булш, хиргисүүрүүд
12. Дэлгэрхаан сумын Хөшөөнө-Ухаа гэдэг газар орших хүн чулуу, тахилын чулуун хавтангууд
13. Дэлгэрхаан сумын Хэрлэнбаян-Улаан уулын Хүйтэн хошуу, Бухын хошууны булшнууд
14. Дэлгэрхаан сумын Хэрлэнбаян-Улаан уулын Хэрээ хошууны булш, хиргисүүрүүд
15. Жаргалтхаан сумын Барууны-Ар гэдэг газар орших хүн чулуун хөшөө
16. Жаргалтхаан сумын Цэнхэрийн голын хэрэм
17. Мөрөн сумын нутагт орших Салбар уулын бичээс

18. Мөрөн сумын Баруун, Зүүн хэрэм
19. Норовлин сумын Чингэсийн хэрмэн зам
20. Өмнөдэлгэр сумын Дээд Өлзийтийн дөрвөлжин булшнууд
21. Өмнөдэлгэр сумын төвд орших буган чулуу хөшөө
22. Өмнөдэлгэр сумын Жаргалант гэдэг газар орших хадны зураг
23. Цэнхэрмандал сумын Бургастай гэдэг газар орших хадны түрэг бичээс

22. Улаанбаатар хот

Улсын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Ардын намын Төв хороо, Ардын Засгийн газар түр байрлаж байсан байшин
2. Анхны "Өндөр хоршоо"-ны 2 давхар байшин
3. Алтан-Өлгий дэх оршуулгын газар
4. Богд хааны ногоон ордон музейн цогцолбор
5. Гандантэгчэнлин хийдийн цогцолбор
6. Гачууртын амны хадны зураг
7. Гэр хэлбэрт модон дуганууд
8. Гэсэр сүмийн цогцолбор
9. Дамбадаржаа хийдийн цогцолбор
10. Дарь-Эхийн сүмийн 2 ширхэг чулуун багана, Гол сүм
11. Их тэнгэрийн амны хадны зураг
12. Сонгинохайрхан уулын булшнууд
13. Сонгинохайрхан уулын өвөрт орших Тоорил ханы ордон хэмээн нэрлэдэг ордны туурь
14. Чин ван Ханддоржийн байшин
15. Чойжин ламын сүм музейн цогцолбор

Нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Анхны европ хоёр давхар байшин
2. Анхны холбооны байшин
3. Сэлбэ голын гүүрний 2 ширхэг чулуун арслан
4. Байгалийн түүхийн музейн өмнөх 2 ширхэг чулуун арслан
5. Богд хааны зуны ордны зарим барилга
6. Бэлхийн амны Хүннүгийн үеийн булшнууд
7. Зүүн хүрээний нууц бүлгэм байрлаж байсан байшин
8. Консулын дэнжийн нууц бүлгэм байрлаж байсан байшин
9. Монгол Улсын их сургуулийн 1 байрны өмнөх 2 ширхэг чулуун арслан
10. Монгол Улсын Ерөнхий сайд П.Гэндэнгийн амьдарч байсан байшин
11. Д.Сүхбаатар жаахны анхны хөшөө

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 176

Улаанбаатар хот

Жагсаалтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Олон улсын байгууллага, гэрээ, конвенцийн итгэмжит санд төлөх татвар, хандивын тухай" Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 60 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Татварыг нь улсын төсвөөс төлөх олон улсын байгууллагуудын жагсаалт"-д "57. Шинжлэх ухаан, техникийн мэдээллийн олон улсын төв-БСШУЯ" гэж нэмсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Шинжлэх ухаан, техникийн мэдээллийн олон улсын төвийн гишүүний 2008 оны татварыг тус байгууллагын нэхэмжлэлийг үндэслэн санхүүжүүлэхийг Сангийн сайд Ч.Улаанд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

САНГИЙН САЙД

Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 177

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Боловсролын тухай хуулийн 39.7, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16.4-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Сургалтын төрийн сангийн хөрөнгийг захиран зарцуулах журам"-ыг 1 дүгээр, Сургалтын төрийн сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар, "Монгол Улсын болон гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад төрийн буцалтгүй тусламж олгох журам"-ыг 3 дугаар, "Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам"-ыг 4 дүгээр, "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам"-ыг 5 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

Н.Болормаа, Сангийн сайд Ч.Улаан нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 1997 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 179 дүгээр тогтоолын 4 дүгээр зүйл, "Журам шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2000 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 96 дугаар тогтоол, "Журам батлах тухай" Засгийн газрын 2000 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн 158 дугаар тогтоол, "Журам, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2001 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 195 дугаар тогтоолын 1-5 дугаар зүйл, "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2002 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн 207 дугаар тогтоол, "Журамд өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2003 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 61 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД

Н.БОЛОРМАА

Засгийн газрын 2008 оны 177 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

СУРГАЛТЫН ТӨРИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ЗАХИРАН ЗАРЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Сургалтын төрийн сан (цаашид "Сан" гэнэ)-гийн үйл ажиллагааг энэхүү дүрмээр зохицуулна.

1.2. Сангийн зорилго нь дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зохих журмын дагуу төрийн буцалтгүй тусламж, зээл олгох, зээлийг эргэн төлүүлэх ажлыг зохион байгуулахад оршино.

1.3. Сангийн үйл ажиллагааны зардлыг жил бүр улсын төсөвт тусгаж байна.

1.4. Сан нь хуулийн этгээд байх бөгөөд улсын бүртгэлд бүртгүүлж зохих журмын дагуу хийсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, банкинд харилцах данстай байна.

Хоёр. Сангийн Удирдах зөвлөл

2.1. Сангийн үйл ажиллагааг удирдан зохицуулах, хөрөнгийн бүрдүүлэлт, хуваарилалтыг чиглүүлэх, зарцуулалтад хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус Удирдах зөвлөл (цаашид "Удирдах зөвлөл" гэнэ) ажиллана.

2.2. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг Засгийн газар батална. Удирдах зөвлөл нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Боловсрол, санхүү, төсөв, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, сургалтын төрийн сангийн төлөөлөлтэй байна.

2.3. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна. Удирдах зөвлөл улиралд 1-ээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай бол зөвлөлийн даргын саналаар ээлжит бус хурлыг хуралдуулж болно. Сургалтын төрийн сангийн захирал (цаашид "захирал" гэнэ) тодорхой асуудлыг удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэх саналаа Удирдах зөвлөлийн даргад тавьж болно. Удирдах зөвлөл нь 75-аас дээш хувийн ирцтэй хуралдах бөгөөд асуудлыг хуралд оролцсон гишүүдийн 75-аас дээш хувийн саналаар шийдвэрлэж, тэмдэглэл гаргана. Хүндэтгэх шалтгаанаар хуралд оролцох боломжгүй гишүүн, саналаа бичгээр урьдчилан өгсөн бол гишүүнийг хуралд оролцсонд тооцно.

2.4. Удирдах зөвлөл нь Сангийн ажлын тайланг хэлэлцэж үнэлэлт, дүгнэлт өгөх, зээлийг эргэн төлүүлэх, чөлөөлөх зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

Гурав. Сангийн захиргаа

3.1. Сангийн захиргаа нь Удирдах зөвлөлийн баталсан хуваарь, зориулалтын дагуу хөрөнгийг хуваарилах, зээлийг эргүүлэн төлүүлэх замаар сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зохистой зарцуулах, тайлагнах, ашиглалтад хяналт тавих үйл ажиллагааг эрхэлнэ.

3.2. Сангийн захиргааны орон тоо, ажиллах журам, санхүүжүүлэх зарчмыг боловсрол болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

3.3. Сургалтын төрийн сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргаж, санхүүжилтийг уг шийдвэрийг үндэслэн Сангийн захиргаа гүйцэтгэнэ.

3.4. Сангийн захиргааг Сангийн гүйцэтгэх захирал удирдана. Гүйцэтгэх захирлыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.

3.5. Захирал нь Сургалтын төрийн сангийн ерөнхий менежер байх бөгөөд сангийн үйл ажиллагааг өдөр тутмын удирдлагаар хангаж, сангийн талаар гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, ажилтнуудын ажил үүргийн хуваарийг баталж, үр дүнгийн гэрээ байгуулж, дүгнэнэ.

3.6. Сан нь буцалтгүй тусламж, зээлд хамрагдаж суралцагчдын бичиг, баримтын бүрдүүлэлт, зээлийг эргэн төлүүлэх асуудлаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллана.

Дөрөв. Сангийн хөрөнгийн эх үүсвэр

4.1. Сангийн хөрөнгийг дор дурдсан эх үүсвэрээс бүрдүүлнэ:

- 4.1.1. улсын төсвийн хөрөнгө;
- 4.1.2. эргэн төлөгдсөн зээлийн хөрөнгө;
- 4.1.3. хандив, тусламж, зээл.

Тав. Сангийн хөрөнгийн зарцуулалт

5.1. Сургалтын төрийн сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээнд зарцуулна:

- 5.1.1. сургалтын төлбөр, амьжиргааны тэтгэлгийн зээл олгох;

5.1.2. сургалтын төлбөр, амьжиргааны тэтгэлэг, замын зардлын буцалтгүй тусламж үзүүлэх;

5.1.3. сургалтын төлбөрийг төрөөс хариуцан үнэ төлбөргүй сургах.

Зургаа. Сангийн бүрэн эрх

6.1. Сан нь дор дурдсан эрхтэй:

6.1.1. зээл, төрийн буцалтгүй тусламжийн гэрээг байгуулах;

6.1.2. сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжаар суралцагчдын сурлага болон шилжилт хөдөлгөөний талаархи мэдээлэл, зээл, тусламжийн зарцуулалтын талаархи мэдээг харилцагч сургуулиас тогтоосон хугацаанд гаргуулан авах;

6.1.3. олгосон зээлийг хариуцагч этгээдээс нэхэмжлэх;

6.1.4. Сангаас олгосон зээлийг эргүүлэн төлөхөөс зайлсхийсэн иргэдэд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх асуудлыг холбогдох хуулийн байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

6.1.5. Сан нь гадаад, дотоодын сан, олон улсын байгууллагатай хамтран ажиллаж, төсөл хэрэгжүүлж болно.

6.2. Сан нь дор дурдсан үүрэгтэй:

6.2.1. Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, тайлагнах ажлыг зохион байгуулах;

6.2.2. амьжиргааны тэтгэлэг, сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, зээлд хамрагдах суралцагчдыг сонгон шалгаруулах;

6.2.3. суралцагчдад амьжиргааны тэтгэлэг, сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, зээл олгох, зээлийн барьцаанд байгаа хөрөнгийн баталгааг бүрдүүлж, эргэн төлөх ажлыг зохион байгуулах;

6.2.4. Сангийн тухайн жилийн төсвийг боловсруулж улсын төсөвт тусгуулах;

6.2.5. Сангийн зээлийн мэдээллийн санг Монгол банкны зээлийн мэдээллийн сантай холбож, хяналт тавин ажиллана.

Долоо. Бусад

7.1. Сан нь гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр суралцагчдын мэдээллийн сан бүрдүүлнэ.

7.2. Сан нь гэрээний биелэлтийн асуудлаар дээд боловсролын сургалтын байгууллагад хяналт, шалгалт хийж, шаардлагатай бол хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллана.

7.3. Сангийн хөрөнгийг журамд зааснаас өөр үйл ажиллагаанд зарцуулахыг хориглоно.

Засгийн газрын 2008 оны 177 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

СУРГАЛТЫН ТӨРИЙН САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга - Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд	зохицуулалтын газрын дарга;
Дэд дарга - Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	-Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга;
Гишүүд : - Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;	-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын боловсролын салбар хармуцсан референт;
-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;	-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны мэргэжлийн боловсролын суралцагчдын асуудал хариуцсан мэргэжилтэн;
-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Санхүү, эдийн засгийн газрын дарга;	-Сангийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газрын боловсрол, соёл, шинжлэх ухааны төсвийн асуудал хариуцсан мэргэжилтэн;
-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Мэргэжлийн боловсролын газрын дарга;	Нарийн бичгийн дарга - Сургалтын төрийн сангийн гүйцэтгэх захирал.
-Сангийн яамны Төсвийн бодлого,	

Засгийн газрын 2008 оны 177 дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН БОЛОН ГАДААДЫН ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД СУРАЛЦАГЧДАД ТӨРИЙН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн дээд боловсролын сургалтын байгууллага (цаашид "сургууль" гэнэ)-ын бакалавр, магистр, докторын өдрийн сургалтад зохих журмын дагуу элсэн суралцаж байгаа Монгол Улсын иргэнд сургалтын төлбөрийн төрийн буцалтгүй тусламж олгох, хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад амьжиргааны тэтгэлэггүйгээр суралцаж байгаа Монгол Улсын иргэнд амьжиргааны тэтгэлгийн буцалтгүй тусламж олгох болон хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа гадаадын иргэнд сургалтын төлбөр, амьжиргааны тэтгэлгийн буцалтгүй тусламж олгоход энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Сургалтын төрийн сан, сургууль, суралцагч хоорондын харилцааг холбогдох хууль тогтоомж болон энэхүү журмаар зохицуулна.

1.3. Энэхүү журмын дагуу төрийн буцалтгүй тусламж авах суралцагч Сургалтын төрийн сантай гэрээ байгуулна. Үг гэрээг үндэслэн суралцагчийн сургалтын төлбөрийг тухайн сургуульд Сургалтын төрийн сангаас тусгай хуваарийн дагуу шилжүүлнэ.

1.4. Тухайн жилд төрийн буцалтгүй тусламжид хамрагдах суралцагчдын хяналтын тоог сургууль тус бүрээр боловсролын болон санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага жил бүрийн 7 дугаар сарын 1-ний дотор тогтоож, холбогдох сургууль, Сургалтын төрийн санд мэдэгдэнэ. Тухайн хичээлийн жилд элсэгч, суралцагчдад хяналтын тоонд багтаан шинээр болон үргэлжлүүлэн олгох хуваарийг мэргэжлээр нь тодорхойлсон байна. Энэ хуваарийг нийтэд мэдээлэх ажлыг тухайн сургууль, Сургалтын төрийн сан зохион байгуулна.

Хоёр. Төрийн буцалтгүй тусламж олгох нөхцөл

2.1. Элсэгчдэд дараахь нөхцөлд сургалтын төлбөр, амьжиргааны тэтгэлгийг Сургалтын төрийн сангаас хяналтын тоонд багтаан буцалтгүй тусламжийн хэлбэрээр олгоно:

2.1.1. боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын

шийдвэрийн дагуу зохион байгуулсан улсын хэмжээний олимпиадад эхний гурван байр эзэлсэн суралцагчийн сургалтын төлбөр;

2.1.2. олон улсын зэрэглэлийн олимпиад, уралдаан, тэмцээнд Монгол Улсыг төлөөлөн амжилттай оролцсон суралцагчийн сургалтын төлбөр;

2.1.3. хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад амьжиргааны тэтгэлэггүйгээр суралцаж байгаа Монгол Улсын иргэний амьжиргааны тэтгэлэг;

2.1.4. бүтэн өнчин суралцагчийн сургалтын төлбөр;

2.1.5. хөгжлийн бэрхшээлтэй суралцагч буюу эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сургалтын төлбөр;

2.1.6. хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн нэг суралцагчийн сургалтын төлбөр;

2.1.7. өрхийн нэг гишүүнд ногдох орлого нь Үндэсний статистикийн хорооноос тогтоосон бусийн амьжиргааны түвшингийн 50 хувиас доогуур орлоготой өрхийн суралцагчийн сургалтын төлбөр;

2.1.8. бог малд шилжүүлснээр өрхийн нэг гишүүнд 50 хүртэл толгой мал ногдох малчин өрхийн нэг суралцагчийн сургалтын төлбөр;

2.1.9. хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа гадаадын иргэний сургалтын төлбөр, амьжиргааны тэтгэлэг.

2.2. Хяналтын тоонд багтаан дараахь нөхцөл хангасан суралцагчдыг шалгаруулан, сургалтын төлбөр, амьжиргааны тэтгэлгийн буцалтгүй тусламжийг шинээр буюу үргэлжлүүлэн олгоно:

2.2.1. сургуулиа төгссөний дараа орон нутагт 3-аас дээш жил ажиллахаар гэрээ байгуулсан суралцагчийн сүүлийн 2 жилийн сургалтын төлбөр;

2.2.2. журмын 2.1.4, 2.1.5-д заасны дагуу буцалтгүй тусламж авч суралцсан

суралцагчийн сурлагын голч дүн 2.0 болон түүнээс дээш байх тохиолдолд, бусад нөхцөлөөр буцалтгүй тусламж авч суралцсан суралцагчийн сурлагын голч дүн 2.8 болон түүнээс дээш байх тохиолдолд гэрээг сунган буцалтгүй тусламжийг үргэлжлүүлж олгоно. Голч дүнгийн үзүүлэлтээр хасагдсан суралцагчийн оронд нэг хичээлийн жилээс илүү хугацаагаар 2.8-аас дээш голч дүнтэй суралцаж байгаа тухайн сургуулийн суралцагчийг Сургалтын төрийн сангаас шалгаруулан буцалтгүй тусламжид хамруулж болно.

Гурав. Бүрдүүлэх материал

3.1. Төрийн буцалтгүй тусламжид хамрагдах суралцагч нь дараахь бичиг баримтыг бүрдүүлэн жил бүрийн 9 дүгээр сарын 1-ний дотор сургуульдаа өгнө.

3.1.1. өргөдөл (тусгай маягтын дагуу);

3.1.2. эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон суралцагчийн иргэний үнэмлэхийн хуулбар;

3.1.3. бүрэн дунд боловсролын гэрчилгээний хуулбар (магистрант, докторантын хувьд бакалавр, магистрын дипломын хуулбар);

3.1.4. энэ журмын 2.1.1, 2.1.2, 2.1.4-2.1.8-д заасан суралцагчийн хувьд сургуульд зохих журмын дагуу элссэнийг нотлох эрхийн бичиг;

3.1.5. энэ журмын 2.1.1-2.1.3, 2.1.9-т заасан суралцагчийн хувьд боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр;

3.1.6. энэ журмын 2.1.4-т заасан суралцагчийн хувьд эцэг, эхийн нас барсны гэрчилгээний хуулбар;

-энэ журмын 2.1.5-д заасан суралцагчийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй болохыг тогтоосон холбогдох байгууллагын тодорхойлолт;

-энэ журмын 2.1.6-д заасан суралцагчийн хувьд өрхийн нэг гишүүнийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан болохыг тогтоосон холбогдох байгууллагын тодорхойлолт;

-энэ журмын 2.1.7-д заасан суралцагчийн хувьд өрхийн нэг гишүүнд ногдох орлогыг тодорхойлсон харьяалах сум, дүүргийн Засаг даргаас баталгаажуулсан албан ёсны бичиг баримт;

-энэ журмын 2.1.8-д заасан суралцагчийн хувьд өрхийн нэг гишүүнд ногдох толгой малын тоо, малчин өрх болохыг нотлох харьяалах сум,

дүүргийн Засаг даргаас баталгаажуулсан албан ёсны бичиг баримт;

-энэ журмын 2.2.1-д заасан суралцагчийн хувьд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр болон аймгийн Засаг даргын Тамгын газартай байгуулсан гэрээ;

-энэ журмын 2.2.2-т заасан суралцагчийн хувьд сургуулийн болон дүнгийн тодорхойлолт.

Дөрөв. Төрийн буцалтгүй тусламжийн санхүүжилт

4.1. Сургалтын төрийн сангийн шугамаар төрийн буцалтгүй тусламж авахыг хүссэн суралцагчдаас батлагдсан хяналтын тоонд багтаан сонгон шалгаруулах ажлыг сургуулийн захирлын тушаалаар байгуулсан комисс хариуцан зохион байгуулна. Комиссын бүрэлдэхүүнд тухайн сургуулийн сургалтын болон оюутны асуудал хариуцсан ажилтан, оюутны байгууллага, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагчийн төлөөллийг оруулна. Комисс нь энэ журмын 3-т заасан материалыг үндэслэн төрийн буцалтгүй тусламжид хамрагдах элсэгч, суралцагчийг жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор сонгон шалгаруулж, дүгнэлтийг Сургалтын төрийн санд хүргүүлнэ.

4.2. Сургалтын төрийн сан нь төрийн буцалтгүй тусламжид хамруулахаар сургуулиас гаргасан дүгнэлтийг үндэслэн суралцагчтай гэрээ байгуулж, төлбөрийг сургуульд нь шилжүүлнэ. Санхүүжилтийн хэмжээ болон суралцагчтай байгуулах гэрээний загварыг боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

4.3. Хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад амьжиргааны тэтгэлэгийгээр суралцаж байгаа Сургалтын төрийн сантай гэрээ байгуулсан Монгол Улсын иргэнд амьжиргааны тэтгэлгийн төрийн буцалтгүй тусламж олгоно. Суралцагчид олгох амьжиргааны тэтгэлгийн хэмжээг холбогдох гэрээ, хэлэлцээрт тодорхой заагаагүй бол тэтгэлгийн хэмжээ болон Сургалтын төрийн сан, суралцагч хооронд байгуулах гэрээний загварыг боловсрол болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. Санхүүжилтийг Монгол Улсаас тухайн оронд суугаа Элчин сайдын ямаар дамжуулан олгоно. Элчин сайдын яам нь жил бүр өөрийн суугаа болон хавсран суугаа оронд суралцаж байгаа Монгол Улсын иргэдийн сурлагын талаархи судалгааг гаргаж, жил бүрийн 10 дугаар сард гадаад хэргийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон Сургалтын төрийн санд ирүүлж байна.

4.4. Хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа гадаадын иргэнд гэрээ, хэлэлцээрт заасан санхүүгийн нөхцөлийн дагуу сургалтын төлбөр, амьжиргааны тэтгэлгийн төрийн буцалтгүй тусламжийг олгоно. Суралцагчдад олгох амьжиргааны тэтгэлгийн хэмжээг холбогдох гэрээ, хэлэлцээрт тодорхой заагаагүй бол боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтарсан шийдвэрээр тогтооно. Санхүүжилтийг Сургалтын төрийн сангаас тухайн суралцагчийн суралцаж байгаа сургуулиар дамжуулан олгоно. Сургууль нь тухайн суралцагч хичээлдээ бүрэн сууж, сургуулиас тавьсан шаардлагыг бүрэн биелүүлж байгаа талаархи мэдээллийг гарган Сургалтын төрийн санд албан ёсоор хичээлийн улирал бүрийн төгсгөлд ирүүлж байна.

4.5. Энэхүү журмын 4.3, 4.4-т заасан төрийн буцалтгүй тусламжид хамрагдаж байгаа суралцагчийн гэрээг сунгах, санхүүжилтийг үргэлжлүүлэн олгох асуудлыг холбогдох сургууль, Элчин сайдын яамны тодорхойлолтыг үндэслэн Сургалтын төрийн сан шийдвэрлэнэ.

4.6. Суралцагч нь чөлөө авсан болон журамд заасан голч дунгийн босгын шаардлага хангахгүй суралцсан тохиолдолд сургуулийн албан ёсны шийдвэр, саналыг үндэслэн гэрээг нь түдгэлзүүлж, санхүүжилтийг түр зогсооно.

Тав. Бусад

5.1. Хоёр дахь дээд боловсрол эзэмшиж байгаа суралцагчид энэхүү журам хамаарахгүй.

5.2. Гэрээ, санхүүжилттэй холбогдон гарсан маргааныг холбогдох хууль тогтоомж, гэрээ, дүрэм, журмаар зохицуулна.

Засгийн газрын 2008 оны 177 дугаар тогтоолын 4 дүгээр хэсрэлт

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН
БАЙГУУЛЛАГАД СУРАЛЦАГЧДАД ЗЭЭЛ ОЛГОХ,
ЭРГЭН ТӨЛҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн дээд боловсролын сургалтын байгууллага (цаашид "сургууль" гэнэ)-ын өдрийн ангид бакалавр, магистр, докторын боловсрол эзэмшихээр зохих журмын дагуу элсэн суралцаж байгаа Монгол Улсын иргэнд сургалтын төлбөрийн зээл олгох, эргэн төлүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Сургалтын төрийн сан, сургууль, суралцагч хооронд байгуулах сургалтын төлбөрийн зээлийн гэрээ (цаашид "зээлийн гэрээ" гэнэ)-ний загвар, санхүүжилтийн хэмжээг боловсрол болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтарсан тушаалаар батална. Зээлийн гэрээнд зээлдэгчийн үүрэг, хариуцлага, зээлийн санхүүжилтийн хугацаа, эргэн төлөх нөхцөлийг тодорхой тусгана. Зээлийн гэрээ байгуулсан суралцагч (цаашид "суралцагч" гэнэ)-ийн сургалтын төлбөрийг Сургалтын төрийн сангаас санхүүжүүлнэ.

1.3. Тухайн жилд сургалтын төлбөрийн зээл авах суралцагчдын хяналтын тоог сургууль болон мэргэжлийн чиглэл тус бүрээр боловсрол болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтарсан тушаалаар жил бүрийн 7 дугаар сарын 1-ний дотор тогтоож, холбогдох сургууль, Сургалтын төрийн санд мэдэгдэнэ. Энэ хуваарийг нийтэд мэдээлэх ажлыг сургууль, Сургалтын төрийн сан зохион байгуулна.

1.4. Сургалтын төрийн сан, сургууль, суралцагч хоорондын харилцааг зээлийн гэрээ, холбогдох журам, хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

Хоёр. Сургалтын төлбөрийн зээл олгох нөхцөл

2.1. Сургалтын төрийн сангаас дараахь нөхцөлд элсэгчийн сургалтын төлбөрийг зээлийн хэлбэрээр олгоно:

2.1.1. хагас өнчин суралцагч;

2.1.2. бог малд шилжүүлснээр өрхийн нэг гишүүнд 100 хүртэл толгой мал ногдох малчин өрхийн суралцагч;

2.1.3. өрхийн нэг гишүүнд ногдох орлого нь Үндэсний статистикийн хорооноос тогтоосон бүсийн амьжиргааны түвшингээс доогуур орлоготой өрхийн суралцагч;

2.1.4. гэрээт цэргийн албыг 2 жилээс доошгүй хугацаагаар хаасан суралцагч.

Гурав. Бүртгэл, шалгаруулалт

3.1. Сургалтын төрийн сангаас сургалтын төлбөрийн зээл авахыг хүссэн, энэ журмын 2.1-т заасан нөхцөл бүхий суралцагч нь дараахь бичиг, баримтыг бүрдүүлэн жил бүрийн 9 дүгээр сарын 1-ний дотор сургуулийнхаа захиргаанд өгнө. Үүнд:

3.1.1. өргөдөл (тусгай маягтын дагуу);

3.1.2. эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон суралцагчийн иргэний үнэмлэхийн хуулбар;

3.1.3. бүрэн дунд боловсролын гэрчилгээний хуулбар;

3.1.4. сургуульд зохих журмын дагуу элссэнийг гэрчлэх эрхийн бичиг;

3.1.5. энэ журмын 2.1.1-д заасан суралцагчийн хувьд эцэг, эхийн аль нэг нь нас барсны гэрчилгээний хуулбар;

3.1.6. энэ журмын 2.1.2-т заасан суралцагчийн хувьд өрхийн нэг гишүүнд ногдох толгой малын тоо, малчин өрх болохыг нотлох харьяалах сум, дүүргийн Засаг даргаас баталгаажуулсан албан ёсны бичиг баримт;

-энэ журмын 2.1.3-т заасан суралцагчийн хувьд өрхийн нэг гишүүнд ногдох орлогыг тодорхойлсон харьяалах сум, дүүргийн Засаг даргаас баталгаажуулсан албан ёсны бичиг баримт;

-энэ журмын 2.1.4-т заасан суралцагчийн хувьд 2 жилээс доошгүй хугацаагаар гэрээт цэргийн албыг хаасныг тодорхойлсон харьяалах сум, дүүргийн Засаг даргаас баталгаажуулсан албан ёсны бичиг баримт;

3.1.7. зээлийг буцаан төлөхийг нотолсон баталгаа.

3.2. Сургалтын төрийн сангаас сургалтын төлбөрийн зээл авахыг хүссэн суралцагчдаас хяналтын тоонд багтаан сонгон шалгаруулах ажлыг сургуулийн захирлын тушаалаар байгуулсан комисс хариуцан зохион байгуулна. Комиссын бүрэлдэхүүнд тухайн сургуулийн сургалтын болон оюутны асуудал хариуцсан ажилтан, оюутны байгууллага, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн төлөөллийг оруулна. Энэ журмын 3.1-д заасан бичиг баримтыг үндэслэн сургалтын төлбөрийн зээл олгох элсэгч, суралцагчийг жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор сонгож, дүгнэлтийг Сургалтын төрийн санд хүргүүлнэ.

3.3. Сургуулиас ирүүлсэн дүгнэлт, суралцагчдын материалыг Сургалтын төрийн

сангаас хянан үзэж, тухайн суралцагчид зээл олгох эсэх асуудлыг эцэслэн шийдвэрлэнэ.

Дөрөв. Сургалтын төлбөрийн зээлийг санхүүжүүлэх, түүнийг зогсоох

4.1. Сургалтын төлбөрийн зээлд хамрагдахаар шалгарсан суралцагч нь Сургалтын төрийн сантай зээлийн гэрээ байгуулна. Зээлийн гэрээ байгуулсан суралцагчийн сургалтын төлбөрийг Сургалтын төрийн сангаас суралцаж байгаа сургуулиар нь дамжуулан санхүүжүүлнэ.

4.2. Сургалтын төлбөрийн зээлд хамрагдаж байгаа суралцагчийн сурлагын голч дүн 2.8 болон түүнээс дээш байх тохиолдолд гэрээг сунгаж, санхүүжилтийг үргэлжлүүлэн олгоно. Голч дүнгийн үзүүлэлтээр хасагдсан суралцагчийн оронд тухайн сургуулийн нэг хичээлийн жилээс доошгүй хугацаагаар 2.8-аас дээш голч дүнтэй суралцаж байгаа суралцагчийг зээлд хамруулж болно.

4.3. Суралцагч нь чөлөө авсан, эсхүл журамд заасан голч дүнгийн босгын шаардлага хангахгүй суралцсан тохиолдолд сургуулийн албан ёсны мэдэгдэл, саналыг үндэслэн гэрээг нь түдгэлзүүлж, санхүүжилтийг түр зогсооно.

4.4. Сургалтын төлбөрийн зээлээр суралцагч сургуулиа төгссөн, өөр сургуульд шилжсэн, сургуулиас гарсан, эсхүл хасагдсан тохиолдолд тухайн сургууль цаг тухайд нь Сургалтын төрийн санд албан ёсоор мэдэгдэнэ.

Тав. Сургалтын төлбөрийн зээлийн эргэн төлөлт

5.1. Суралцагч сургалтын төлбөрийн зээлийг сургууль төгссөнөөс хойш зээлийн гэрээний дагуу төлнө. Зээлийг эргэн төлөх дээд хугацаа нь 5 жил байна.

5.2. Төгсөгч хөдөлмөрийн гэрээ байгуулснаас эхлэн түүний үндсэн цалин болон бусад орлогын 50 хүртэл хувиар тооцон зээлийн эргэн төлөх хуваарь гаргаж, 5 хүртэл жилийн хугацаанд Сургалтын төрийн санд шилжүүлэх ажлыг төгсөгч, ажил олгогч нар хамтран гүйцэтгэнэ.

5.3. Төгсөгч, ажил олгогч нь сургалтын төлбөрийн зээлийг хугацаанаас нь өмнө төлж барагдуулж болно.

5.4. Суралцагч нас барсан, хөдөлмөрийн чадвараа 70 болон түүнээс дээш хувиар алдсан тохиолдолд түүнийг зээлийн төлбөрөөс чөлөөлнө.

5.5. Сургалтын төрийн сангийн зээлээр суралцагч нийслэлд төсвийн байгууллагад 5-аас доошгүй жил, орон нутагт төсвийн байгууллагад 3-аас доошгүй жил тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажилласан тохиолдолд түүнийг зээлийн төлбөрөөс чөлөөлнө.

5.6. Энэ журмын 5.4, 5.5-д заасан нөхцөлөөр зээлийн төлбөрөөс чөлөөлөх асуудлыг Сургалтын төрийн сан холбогдох этгээдээс нотлох бичиг, баримт авсны үндсэн дээр Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж дүгнэлт гаргуулан Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ.

5.7. Суралцагч зээлийн гэрээгээ зөрчсөн тохиолдолд зээлийг хүүгийн хамт Сургалтын төрийн санд буцаан төлнө.

Зургаа. Бусад

6.1. Сургалтын төлбөрийн зээл авах, эргэн төлөгдөх үндэслэл нь суралцагч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс гаргах хөрөнгийн барьцаа, баталгаа байна. Зээлийн батлан даалтыг ажил олгогч, эсхүл сонирхсон гуравдагч этгээд хариуцан гаргаж болно.

6.2. Хоёр дахь дээд боловсрол эзэмшиж байгаа суралцагчид энэхүү журам хамаарахгүй.

6.3. Сургалтын төрийн сан нь зээл авсан суралцагчдын нэгдсэн бүртгэл, тооцоог хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэн жил бүр статистик мэдээ гаргана.

6.4. Сургалтын төлбөрийн зээлийн гэрээ, санхүүжилт, эргэн төлөхтэй холбогдон гарсан маргааныг холбогдох хууль тогтоомж, гэрээ, дүрэм, журмаар зохицуулна.

Засгийн газрын 2008 оны 177 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт

ГАДААДЫН ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД СУРАЛЦАГЧДАД ЗЭЭЛ ОЛГОХ, ЭРГЭН ТӨЛҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Олон улсад нэр хүндтэй, гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад зохих журмын дагуу элссэн оюутан, магистрант, докторант (цаашид "суралцагч" гэнэ)-ын сургалтын төлбөр, амьжиргааны тэтгэлэг, эрдэм шинжилгээний ажлын хамгаалалтын зардлыг Сургалтын төрийн сангаас зээлийн хэлбэрээр санхүүжүүлэхэд энэхүү журмыг баримтална.

1.2. Суралцагчийг шалгаруулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

1.3. Суралцагч нь иргэний хуулийн дагуу итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй байна. Суралцагчийг эх орондоо байхгүй байх хугацаанд түүний эрх, үүргийг итгэмжлэгдсэн төлөөлөгч нь төлөөлнө.

1.4. Суралцагч нь захиалагч байгууллага (цаашид "захиалагч" гэнэ), итгэмжлэгдсэн төлөөлөгч, Сургалтын төрийн сантай зээлийн гэрээ байгуулж, жил бүр сунгана.

1.5. Зээлийн гэрээ (цаашид "гэрээ" гэнэ)-ний загвар болон зээлийн хэмжээг боловсрол болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын

гишүүд хамтран батална. Гэрээнд суралцагч болон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тухай мэдээлэл, суралцах хугацаа, сургууль, мэргэжлийн чиглэл, суралцагчийг төгсөж ирсний дараа ажиллуулах захиалагч байгууллага, ажиллах хугацаа болон талуудын харилцан хүлээх бусад эрх, үүрэг, гэрээний нөхцөл зөрчигдсөн тохиолдолд талуудын хүлээх хариуцлагыг тодорхой тусгасан байна.

Хоёр. Бүрдүүлэх материал

2.1. Суралцагч нь гэрээ байгуулахдаа дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ:

2.1.1. өргөдөл (тусгай маягтын дагуу);

2.1.2. суралцуулах тухай боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний болон захиалагч байгууллагын шийдвэрийн хуулбар;

2.1.3. итгэмжлэгдсэн төлөөлөгчөө томилсон тухай итгэмжлэл;

2.1.4. өөрийн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн иргэний үнэмлэхийн хуулбар;

2.1.5. боловсролын баримт бичгүүдийн хуулбар;

2.1.6. зээлийг эргэн төлөх баталгаа болох үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ;

2.1.7. гэрээ (Эд хөрөнгийн улсын бүртгэлийн газрын тэмдэглэл хийлгэсэн байна);

2.1.8. суралцах сургуулийн урилга, сургалтын зардлын нэхэмжлэл, харилцах данс.

Гурав. Санхүүжилт

3.1. Гэрээ байгуулсан суралцагчийн санхүүжилтийг суралцах сургуулийн дансанд Сургалтын төрийн сангаас шилжүүлнэ.

3.2. Үндсэн сургалт эхэлсэн тухай холбогдох сургуулиас ирүүлсэн албан бичгийг үндэслэн эхний хагас жилийн санхүүжилтийг, мөн сургуулиас ирүүлсэн тодорхойлолт, сурлагын дүн, кредит цагийн хэмжээг үндэслэн дараагийн жилийн санхүүжилтийг олгох асуудлыг Сургалтын төрийн сан шийдвэрлэнэ.

Дөрөв. Бусад

4.1. Нэг суралцагчид нэг удаа зээл олгоно.

4.2. Суралцагч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр санхүүжилтээ тузайн ондоо

багтааж ашиглаагүй тохиолдолд санхүүжилтийг зогсооно.

4.3. Магистрантурт суралцах хугацаа 2 жилээс, докторантурт суралцах болон нэг суралцагчид зээл олгох нийт хугацаа 3 жилээс илүүгүй байна.

4.4. Суралцагч гэрээгээ зөрчсөн тохиолдолд зээлийг хүүгийн хамт Сургалтын төрийн санд буцаан төлнө.

4.5. Зээлийг эргэн төлүүлэх асуудлыг Сургалтын төрийн сан хариуцах бөгөөд энэ асуудлаар захиалагч байгууллага болон холбогдох хуулийн байгууллагуудтай хамтран ажиллана.

4.6. Суралцагч амжилттай суралцан төгсөөд гэрээнд заасан байгууллагад 5-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан тохиолдолд зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөх хүсэлт гаргаж болно. Зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөх хүсэлт гаргасан иргэний асуудлыг Сургалтын төрийн сангийн Удирдах зөвлөл хэлэлцэн, дүгнэлтийг Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ.

4.7. Энэ журмын хэрэгжилтийн явцад гарсан маргааныг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 178

Улаанбаатар хот

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Сургалтын төрийн сангийн зээлээр гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцан төгсч, эзэмшсэн мэргэжлээрээ 5 болон түүнээс дээш жил үр бүтээлтэй ажиллаж байгаа 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий хүмүүсийг сургалтын төлбөр болон амьжиргааны тэтгэлгийн зээл, түүний хүүгийн төлбөрөөс, 2007-2008 оны хичээлийн жилээс өмнө Монгол Улсын их, дээд сургууль, коллежийг 2,8

Зарим хүмүүсийг Сургалтын төрийн сангийн зээл, түүний хүүгийн төлбөрөөс чөлөөлөх тухай

болон түүнээс дээш голч дүнтэй төгсч, эзэмшсэн мэргэжлээрээ 2 болон түүнээс дээш жил үр бүтээлтэй ажиллаж байгаа хүмүүсийг 2 дугаар хавсралтын дагуу төлбөрийн зээл, түүний хүүгийн төлбөрөөс бүрэн чөлөөлөхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Н.Болормаа, Сангийн сайд Ч.Улаан нарт зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Н.БОЛОРМАА

Засгийн газрын 2008 оны 178 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

ГАДААДЫН ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛАГАД СУРГАЛТЫН
ТӨРИЙН САНГИЙН ЭЗЭЛЭЭР СУРАЛЦАН ТОГСООД 5 БОЛОН ТҮҮНЭЭС
ДЭЭШ ЖИЛ АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮМҮҮСИЙН СУДАЛГАА

Д/д	Овог нэр	Төгсөн	Улс	Сургууль	Мэргэжил	Зэрэг	Захи- лагч	Зэвгийн дүн (ам дол- лароор)	Ажиллаж байгаа байгууллага
1	Дугаржав Отгончимэг	2003	ХБНГУ	Бременийн Их сургууль	иргэний эрх зүй	магистр	ХЗЯ	16250	2003 оноос одоог хүртэл ХЗДХЯ-д хууль зүйн бодлогын газарт мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн зэрэг ажил хийж байна
2	Доржсүрэн Дуламсүрэн	2003	ХБНГУ	Бременийн Их сургууль	оюуны өмчийн эрх зүй	магистр	ХЗЯ	14722.39	2003 оноос ХЗДХЯ-д ахлах мэргэжилтэн, 2007 оноос одоог хүртэл Аалгатай тэмцэх газарт ажиллаж байна
3	Маньбадрах Ганболд	2001	ОХУ	ДЯЯ-ны удирдлагын академи	зохион байгуулалт	магистр	ЦЕГазар	14700	2001 оноос ЦЕГ-ын ЗЦГ-ын дарга, 2006 оноос өнөөг хүртэл ЦЕГ-т ажиллаж байна
4	Лундэгдамба Сүхээ	2001	ОХУ	ДЯЯ-ны удирдлагын академи	удирдлага	магистр	ЦЕГазар	14500	2001 оноос Цагдан хорих төвийн дарга, 2002 оноос өнөөг хүртэл ЦЕГ-ын Хэрэг бүртгэх газрын даргаар ажиллаж байна
5	Цэвэгмид Амгаланбаяр	2000	ОХУ	ДЯЯ-ны удирдлагын академи	удирдлага	магистр	ЦЕГазар	14500	2000-2006 онд Замын цагдаагийн газрын даргаар, 2006-2007 онд Цагдаагийн академийн захирлаар, 2007 оноос Онцгой байдлын ерөнхий газрын даргаар ажиллаж байна
6	Цоодол Ичиноров	2002	ОХУ	ДЯЯ-ны удирдлагын академи	хууль	магистр	ХЗДХЯ	10025	2002 оноос ЦЕГ-ын жижүүрийн шүүрхэй албаны хэлтсийн дарга, 2003 оноос Эрүүгийн цагдаагийн газрын хэлтсийн даргаар ажиллаж байна
7	Түвэд Батбаяр	2003	ОХУ	ДЯЯ-ны удирдлагын академи	хууль	магистр	ХЗДХЯ	10025	2003 оноос өнөөг хүртэл ЗЦГ-ын тамгын хэлтсийн даргаар ажиллаж байна
8	Сандаг Отгонбаатар	2002	ОХУ	ДЯЯ-ны удирдлагын академи	хууль	магистр	ХЗДХЯ	10025	2002 оноос өнөөг хүртэл нийслэлийн ХУД-ийн Цагдаагийн хэлтсийн даргаар ажиллаж байна
9	Чойжил Ганболд	2003	ОХУ	ДЯЯ-ны удирдлагын академи	хууль	магистр	ХЗДХЯ	10025	2003 оноос ЦЕГ-ын Хянан шалгах, Тусгай тасгийн зохион байгуулалч, 2004 оноос өнөөг хүртэл Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтсийн даргаар ажиллаж байна

10	Сүхбаатар Буянжаргал	2001	ОХУ	Хуулийн Дээд сургууль	криминалистик	бакалавр	ЦЕГ газар	2151.3	1998 оноос СБД-ийн ЦХ-ийн эрүүгийн төлөөлөгч, 2002 оноос өнөөг хүртэл Мөрдөн байцаах газраар ахлах мөрдөн байцагчаар ажиллаж байна.
11	Бончарч Баттогтох	2001	ОХУ	Хуулийн Дээд сургууль	криминалистик	бакалавр	ЦЕГ газар	2151.3	1999 оноос Криминалистик шинжилгээний төвд шинжэн, 2001 оноос Дархан-Уул аймгийн ЦГ-т ахлах шинжээч, 2006 оноос өнөөг хүртэл Дархан-Уул аймгийн ЦГ-т ахлах шинжээчээр ажиллаж байна.
12	Дамдинжамц Ганбат	2001	ОХУ	Хуулийн Дээд сургууль	криминалистик	бакалавр	ЦЕГ газар	2151.3	1998 оноос СХД-ийн ЦХ-ийн эрүүгийн төлөөлөгч, 2002 оноос ЗЦГ-т ахлах төлөөлөгч, 2006 оноос одоог хүртэл СХД-ийн ЦХ-т хэрэг бүртгэгчээр ажиллаж байна.
13	Дамбажав Ганболд	2001	ОХУ	Дипломатын академи	дипломат	магистр	УИХТГ	22500	2002 оноос одоог хүртэл ГХЯ-ны Есолойн хэлтэст атгаше, Төрийн захиргааны удирдлагын газраар атгаше, НҮБ-ын байнгын төлөөлөгчийн газраар атгаше. Консулын газраар 3-р нарийн бичгийн дарга зэрэг ажил хийж байна.
14	Ухнаа Бурмаа	2002	Англи	Вестминстер Их сургууль	гадаад харилцаа	магистр	УИХТГ	38417.11	2003 оноос Аялал жуулчлалын газраар маркетингийн албаны дарга, 2004 оноос одоог хүртэл ЗТАЖЯ-нд мэргэжилтнээр ажиллаж байна.
15	Бархас Дорж	1999	Англи	Дипломатын академи	дипломат	магистр	ГХЯ	10329.6	1999 оноос одоог хүртэл ГХЯ-ны Улс төрийн газраар мэргэжилтэн, Хөвсгөл мэдээллийн хэлтсийн дарга, Польш Улсад суугаа ЭСЯ-нд зөвлөх зэрэг ажлыг хийж байна.
16	Хишигдэлгэр Даваадорж	2003	ОХУ	Дипломатын академи	Олон улсын эдийн засаг	магистр	ГХЯ	9025	2003 оноос одоог хүртэл ГХЯ-ны Азийн газраар 3-р нарийн бичгийн дарга, Австра Улсад суугаа ЭСЯ-нд 1-р нарийн бичгийн дарга зэрэг ажил хийж байна.
17	Мундагбаатар Батсайхан	2000	Франц	Сорбоны Их сургууль	Олон улсын эдийн засаг	магистр	ГХЯ	10900	2000 оноос одоог хүртэл ГХЯ-ны Есолойн хэлтэст мэргэжилтэн, Европийн газраар атгаше, Франц Улсад суугаа ЭСЯ-нд атгаше, ГХЯ-нд мэргэжилтэн зэрэг ажил хийж байна.
18	Хасаг Рагчаа	1999	Англи	Бат хотын Их сургууль	Эдийн засаг	магистр	СЯ	40642.48	2000 оноос одоог хүртэл Сангийн яаманд мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, Санхүүгийн бодлого зохицуулалтын газрын даргаар ажиллаж байна.

19	Жигжид Ганбат	2003	АНУ	Колорадогийн Их сургууль	Эдийн засаг	Магистр	СЗЗЯ	32000	2003 оноос одоог хүртэл Сангийн яаманд мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, Төсвийн бодлого зохицуулалтын газрын Орлогын хэлтсийн даргаар ажиллаж байна
20	Дашням Болдбаатар	1999	ОХУ	ЭЗ Академи	Эдийн засаг	доктор	СЯ	5750	2000 оноос СЯ болон Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн эдийн засгийн асуудал эрхэлсэн орлогч даргын ажлыг хийж байна
21	Дүнхэр Батмөнх	2003	АНУ	Колорадогийн Их сургууль	Эдийн засаг	магистр	СЗЗЯ	32000	2003 оноос одоог хүртэл СЯ-нд мэргэжилтэн, 2005 оноос СЯ-ны Дэлхийн банкны төслийн ажилтнаар ажиллаж байна
22	Даваа Хангал	2002	АНУ	Ютагийн Их сургууль	нв-бо бүртгэл	магистр	СЯ	16000	2002 оноос УХЯ-ны төслийн мэргэжилтэн, 2003 оноос ХХБанкинд захирлын туслах-орчуулгач, 2004 оноос Үндэсний аудитын газарт, 2006 оноос Төрийн албаны зөвлөлийн төслийн зөвлөхөөр ажиллаж байна
23	Ганзориг Тогтохбаатар	2002	АНУ	Колорадогийн Их сургууль	Эдийн засаг	магистр	СЯ	32000	2002 оноос одоог хүртэл Монгол банкнд мэргэжилтэн болон Дотоод аудитын газрын захиргаар ажиллаж байна
24	Лхагва Ганбат	2003	АНУ	Колорадогийн Их сургууль	Бизнесийн удирдлага	магистр	Монгол банк	40000	2003 оноос ТЭХЯ-нд Хамтэн ажиллаганы хэлтсийн дарга, 2005 оноос Бельгийн Вант Улсад Эрчим хүчний хартын нарийн бичгийн дарга, 2006 оноос ТӨХ-ны хэлтэс, газрын даргаар ажиллаж байна
25	Дүрээ Одхүү	2001	АНУ	Доминикан коллеж	хэлний	магистр	ТӨХ	14580	2000 оноос ТӨХ-ны Хамгарсан үйлдвэрийн газрын дарга, 2004 оноос УИХ-ын гишүүн
26	Шовоохой Жаргалсайхан	2002	ОХУ	Дипломатын академи	Олон улсын харилцаа	магистр	Төрийн тусгай хамгаалалтын газар	10025	2002 оноос "Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсийн Худалдаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Тамгын газрын дарга, Зохиолчийн албаны даргаар ажиллаж байна
27	Содовсүрэн Наранчимэг	1999	АНУ	Орегоны Их сургууль	сувилахуй	магистр	ЭМНХЯ	15400	1999 оноос одоог хүртэл ЭМШУИС-ийн Мэргэжил дэвшилгүй институт, ШКТЗ-ийн Сувилахуйн заалах, ЭМШУИС-ийн Сувилахуйн гэнэтийн эрхлэгчээр ажиллаж байна

28	Лувсандорж Эрдэнэбаяр	1997	ОХУ	Сэтгэцийн ЭМХТ	нэркологи	доктор	СЭМСТөв	3500	1997 оноос одоог хүртэл ЭМЯ-ны харьяа Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирлаар ажиллаж байна. 2000 оноос СХД-ийн ЭМНэгдлийн дарга, 2001 оноос ХӨСҮТ-ийн захирал, 2005 оноос одоог хүртэл АУУХүрээлэнгийн орлогч захирал бөгөөд эрдэмтэн нарийн бичгийн даргын ажлыг хийж байна.
29	Дэнсмаа Бат-Очир	2001	ОХУ	Эмч нарын мэргэжл дээшлүүлэх Институт	Эрүүл мэндийн удирдлага	доктор	ЭМНХЯ	2500	2000 оноос Улаан клиникийн 2-р эмнэлэгт их эмч, "Эрэл" эмнэлгийн эмч, 2007 оноос өнөөг хүртэл ЭМШУУС-ийн Зүрх, судасны тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байна.
30	Өнөржаргал Цолмон	2000	АНУ	Орегоны Их сургууль	Зүрх судлал	магистр	ЭМНХЯ	19000	2003 оноос одоог хүртэл МУИС-ийн Мэдээлэл, технологийн сургуульд багшаар ажиллаж байна.
31	Содов Энхболд	2000	АНУ	Бриджпортын Их сургууль	электроник	магистр	Гэгээр- лийн яам	32773	2003 оноос одоог хүртэл МУИС-ийн Математик, компьютерийн сургуульд багшаар ажиллаж байна.
32	Хорлоо Оюундолгор	2003	АНУ	Колорадагийн Их сургууль	компьютер	магистр	Гэгээр- лийн яам	32000	2002 оноос одоог хүртэл БСШУЯ-ны Бага, дунд боловсролын газрын даргаар, Тэгш хамруулах боловсролын нэгжийн ажилтнаар ажиллаж байна.
33	Чагаа Пүрэв-Очир	2002	Англи	Рехемптоны Их сургууль	боловсролын удирдлага	магистр	Гэгээр- лийн яам	14602.4	2003 оноос одоог хүртэл БСШУЯ-ны ШУТГ-ын орлогч, дарга, мэргэжилтнээр ажиллаж байна.
34	Булгаа Ганбат	2003	Япон	Хирошима Их сургууль	боловсрол судлал	магистр	Гэгээр- лийн яам	38025	2000 оноос ХААИС-ийн харьяа УТТСЭШ
35	Жигжээ Мижиддорж	2000	ОХУ	Барнаулын ХАА-н академи	газар тарвиалан	доктор	Гэгээр- лийн яам	4500	Хүрээлэнгийн тэнхимийн эрхлэгч, 2002 оноос Хүрээлэнгийн ерөнхий захирлаар ажиллаж байна.
36	Шажинбат Армунаа	2003	ХБНГУ	Билефельдийн Их сургууль	философи	Магистр	Гэгээр- лийн яам	28105.14	2003 оноос өнөөг хүртэл ХУИС-д тэнхимийн эрхлэгч, салбар сургуулийн эрхлэгч, дэд захирал зэрэг ажлыг хийж байна.
37	Баатар Очирбат	2001	Норвег	Бергений Их сургууль	мэдээлэл зүй	Магистр	Гэгээр- лийн яам	16000	2003 оноос ШУТИС-ийн Математикийн сургуульд профессор, салбарын эрхлэгч, 2008 оноос одоог хүртэл ШУТИС-ийн КТМС-д захирлаар ажиллаж байна.

38	Батсуурь Золтуяа	2001	Швейцар	Женевийн Их сургууль	Олон улсын харилцаа	Магистр	Гэгээр- лийн яам	35543.1	2002 оноос УИХ-ын Байнгын хорооны нарийн бичгийн дарга, 2003 оноос одоог хүртэл УХР-ны ХЭХАГ-г мэргэжилтэн, эхлэх мэргэжилтнээр ажиллаж байна
39	Ойдовжамц Ирина	2003	АНУ	Texas A&M Их сургууль	англи хэл заах арга	Магистр	БСШУЯ	31500	2003 оноос одоог хүртэл ХУИС-д багшаар ажиллаж байна
40	Батхүү Баттулга	2002	Франц	Эколе Суперieur Электре Их сургууль	мэдээлэл зүй	доктор	БСШУЯ	5865	2002 оноос өнөөг хүртэл ШУА-ийн Орон орон, геофизикийн судалгааны төвд ЭШ-ний ажилтан хийж байна
41	Намхай Тунгалаг	2003	Украин	Харьковын Их сургууль	астрофизик	Магистр	ШУА	9845	2003 оноос одоог хүртэл ШУА-ийн Орон орон, геофизикийн судалгааны төвд ЭШ-ний ажилтан хийж байна
42	Гэлэг Цагаач	1999	Голланд	Нийгмийн судалгааны институт	Хүн ам зүй статистик	Магистр	МУИС ЭЗДС	19600	1999 оноос одоог хүртэл МУИС- ийн ЭЗС-ийн Статистийн тэнхимд багш, 2006 оноос Тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байна
43	Шагдар Болормаа	1999	Англи	Манчестерийн Их сургууль	Эдийн засаг	Магистр	УБИС	24178.8	2000 оноос одоог хүртэл МУБИС- ийн Математик, статистийн сургуульд багшаар ажиллаж байна
44	Гэрэл Мягмаржав	2003	ОХУ	Москвагийн Цэргийн Их сургууль	сурган	доктор	БХЯ	3000	2003 оноос одоог хүртэл Баглан хамгаалахын ЭШ-ийг хуралдааны Цэргийн-Иргэний харилцааны судалгааны төвийн даргаар ажиллаж байна
45	Баатархүү Жавхлан	2002	АНУ	Westbind-ын академи	Нисэхийн инженер	бакалавр	ДБХЯ ЗТАЖА	39721	2002 оноос одоог хүртэл "ИРАТ" ХК-д нисгэгчээр ажиллаж байна
46	Далхаа Мөнхцэцэг	2003	Англи	Ноттингамын Их сургууль	геодези	Магистр	ДБЯ БХБЯ	16000	2003 оноос одоог хүртэл Газрын харилцаа, геодези, зураг зүйн газарг ахлах мэргэжилтнээр ажиллаж байна
47	Батсайхан Болормаа	2001	ХБНГУ	Констанцын Их сургууль	гадаад худалдаа	Магистр	ХААУЯ	28718.89	2003 оноос "Монгол чөлөө" ХХК-д менеджер, 2003 оноос УХР-ны Худалдааны Бодлого хамтын ажиллагчаны газарт мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, 2006 оноос одоог хүртэл НҮБ-ын Женев дэх Байнгын төлөөлөгчийн газарт 3-р нарийн бичгийн даргаар ажиллаж байна

48	Мөнжаргал Тодбилэг	2003	Голланд	Байгалийн Уханы олон улсын их сургууль	ашигт малтмалын хайгуул	Магистр	УХЯ	12334	2003 оноос АМУХЭГ-т геологич, 2007 оноос УХЯ-ны геологич, уул уурхай, хүнд үйлдвэрийн газарт мэргэжилтнээр ажиллаж байна
49	Натаа Оюундэлгэр	2003	АНУ	Колорадогийн Их сургууль	агрономи	Магистр	ХААУЯ	31102	2003 оноос одоог хүртэл ХХААЯ- ны Гадаад хамтын ажиллагааны хэлтэст мэргэжилтнээр ажиллаж байна
50	Содном Батсайхан	2000	Англи	Рийдийн Их сургууль	мал эмнэлэг	Магистр	ХААУЯ	30959.78	2001 оноос ХХААЯ-ны Улсын мал эмнэлгийн газрын эпидемиологийн ахлах мэргэжилтэн, 2002 оноос Өрхийн амьжиргааг дэмжих хөтөлбөрийн газарт Тогтвортой амьжиргаа төслэйн зохицуулагч-аар ажиллаж байна
	НИЙТ ДҮН							930168.6	

Засгийн газрын 2008 оны 178 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

**2004-2007 онд МОНГОЛ УЛСЫН ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН
БАЙГУУЛЛАГАД СУРГАЛТЫН ТӨРИЙН САНГИЙН ЗЭЭЛЭЭР СУРАЛЦАН
ТӨГСӨӨД 2 БОЛОН ТҮҮНЭЭС ДЭЭШ ЖИЛ АЖИЛЛАЖ БАЙГАА
ХҮМҮҮСИЙН СУДАЛГАА**

д/д	Төгссөн он	Төрийн өмчийн сургууль		Төрийн бус өмчийн сургууль		Дүн		Үүнээс 2 болон түүнээс дээш жил ажилласан	
		Төгсөгчийн тоо	Зээлийн дүн (мян. төг)	Төгсөгчийн тоо	Зээлийн дүн (мян. төг)	Төгсөгчийн тоо	Зээлийн дүн (мян. төг)	Төгсөгчийн тоо	Зээлийн дүн (мян. төг)
1	2004	1409	1309825.8	183	150711	1592	1460536.8	1114	1022375.8
2	2005	1121	1157259.5	184	159158.4	1305	1316417.9	914	921492.5
3	2006	1159	1213770.4	204	183327.2	1363	1397097.6	954	977968.3
	ДҮН	3689	3680855.7	571	493196.6	4260	4174052.3	2982	2921836.6

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 180

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 11.1.4-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Их Монгол Улс байгуулсны 802 жил, Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 87 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардагдах 150,0 (нэг зуун тавин) сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргаж санхүүжүүлэхийг Сангийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

2. "Улаанбаатар-Лүн-Эрдэнэсант"-ын чиглэлийн авто замын Нийслэлийн авто замын

шалган нэвтрүүлэх 22-ын товчооноос хурдан морины уралдааны зам хүртэлх хэсгийг 2008 оны 7 дугаар сарын 5-ны дотор ашиглалтад оруулж уг замаас хурдан морины уралдааны барианы газрын үзэгчдийн талбай хүртэлх 2.3 км авто замыг барихад шаардагдах 380,0 (гурван зуун наян) сая төгрөгийг төсвийн багцдаа багтаан санхүүжүүлж мөн хугацаанд ашиглалтад оруулахыг Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Р.Рашид даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
С.БАЯР
**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД**
М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 182

Улаанбаатар хот

Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарыг хувьчлах, өөрчлөн байгуулах чиглэл батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 33 дугаар зүйл, "Төрийн өмчийг 2005-2008 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын 2005 оны 48 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарыг хувьчлах, өөрчлөн байгуулах чиглэл"-ийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Дээрх чиглэлд тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж дүнг Засгийн газарт жил бүр танилцуулж байхыг Барилга, хот

байгуулалтын сайд Ц.Цолмон, Төрийн өмчийн хороо (Д.СУГАР), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Нийтийн аж ахуй, ахуйн үйлчилгээний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1995 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 51 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
С.БАЯР
**БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН САЙД**
Ц.ЦОЛМОН

Засгийн газрын 2008 оны 182 дугаар тогтоолын хавсралт

НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫГ ХУВЬЧЛАХ, ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ ЧИГЛЭЛ

Нэг. Зорилго

1.1. Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын эдийн засгийн үр ашиг, хөрөнгийн ашиглалт, ажлын чанарын түвшин, үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх, бүтэц, зохион байгуулалтыг зах зээлийн нөхцөл шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж өрсөлдөх чадварыг сайжруулах, хүн амын ажиллаж амьдрах таатай

нөхцөл бүрдүүлэн тус салбарын байгууллагыг хувьчлах, өөрчлөн байгуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд энэхүү чиглэлийг баримтална.

Хоёр. Хэрэгжүүлэх зорилт

Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарыг хувьчлах, өөрчлөн байгуулах чиглэлийг хэрэгжүүлэхийн тулд дараахь зорилтыг дэвшүүлж байна:

2.1. Хот суурин газрын усан хангамж, бохир ус цэвэрлэх байгууламж, орон сууцны дэд бүтэц, хот тохижилт, нийтийн халуун ус, хатуу хог хаягдлын үйлчилгээг эдийн засгийн хувьд бие даан хөгжүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчинг бүрдүүлэх;

2.2. Хэрэглэгчдийг хэрэгцээний ус, дулаанаар горимын дагуу хангах, бохир усыг татан зайлуулах, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээг мэргэжлийн түвшинд гүйцэтгэх, хог хаягдал, хороолол орчны тохижилт зэрэг иргэдэд хүргэх үйлчилгээг оршин суугчид ая тохитой, аюулгүй амьдарч, ажиллах орчинг бүрдүүлэх нөхцөлийг хангах;

2.3. Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарт төрийн оролцоог багасгаж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт болон хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж үйлчилгээний хүрээг өргөтгөн ажлын чанар, хүртээмжийг сайжруулах;

2.4. Зах зээлийн харилцааны үндсэн зарчмыг баримтлан нийслэл, орон нутгийн нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны онцлог, тухайн нөхцөл байдлыг харгалзан хувьчлалын тохиромжтой арга, хэлбэрийг сонгон хэрэгжүүлэх;

2.5. Эрх зүйн орчинг боловсронгуй болгох замаар нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагад мөрдөж байгаа ажил, үйлчилгээний үнэ тарифыг зах зээлийн зарчим, бодит зардалтай нь уялдуулан тогтоож, мөрдүүлэх;

2.6. Хот суурин газрын эрүүл ахуй, ариун цэврийн норм норматив, стандартыг зөрчсөн нийтийн аж ахуйн үйлчилгээг эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын буруутай үйл ажиллагаанаас хамаарсан хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох.

Гурав. Хувьчлах, өөрчлөн байгуулах чиглэлийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим, хугацаа

Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарыг хувьчлах, өөрчлөн байгуулахад дараахь зарчмыг баримтална:

3.1. Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагыг хувьчлахад үйл ажиллагааны үндсэн чиглэлийг нь өөрчлөхгүй байх нөхцөлтэйгээр холбогдох хууль тогтоомжийн дагуу ил тод явуулах;

3.2. Тухайн байгууллагад улсын төсвөөс оруулсан хөрөнгө оруулалт, гадаад, дотоодын зээл, тусламж, төсөл, арга хэмжээг харгалзан нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагыг орон нутгийн

болон төрийн өмчит хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн зохион байгуулсны үндсэн дээр хувьчлах;

3.3. Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллага нь менежментийн гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай биелүүлсэн тохиолдолд орон нутгийн болон төрийн өмчийн 10 хуртэл хувийг менежментийн баг болон тухайн байгууллагын ажилтнуудад "хувьцаа эзэмшүүлэх сан" хөтөлбөрийн хүрээнд үе шаттайгаар хувьчлах;

3.4. Хэрэглэгчдийн аюулгүй байдлын баталгааг хангах үүднээс хот суурин газрын төвлөрсөн ус хангамжийн байгууламж, усны эх үүсвэрийн үйлчилгээг эрхэлдэг компанийн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоо 51-ээс дээш хувьтай байх;

3.5. Төв, орон нутгийн нийтийн аж ахуйн үйлчилгээний компани нь өөрийн хуучирч муудсан шугам сүлжээг шинэчлэх, шинээр барьж байгуулахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг хувьцааныхаа 49.0 хуртэл хувьд шинээр хувьцаа болон бонд гаргах замаар шийдвэрлэж болох;

3.6. Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагыг менежментийн гэрээгээр ажиллаагүй боловч эрхэлж байгаа үйл ажиллагааны цар хүрээ, ажлын чанар, үр дүн, орон нутгийн онцлогийг харгалзан энэхүү чиглэлийн 3.3-т заасны дагуу хувьчилж болох;

3.7. Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагын өмчлөх хөрөнгийн хэмжээ, хувьчлах арга, хэлбэр, журмыг нийтийн аж ахуйн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Төрийн өмчийн хороо, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хамтран холбогдох хууль тогтоомжийн дагуу тогтоох;

3.8. Нийтийн аж ахуйн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь салбарын байгууллагыг хувьчлах ажлыг зохион байгуулахад мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, шаардлагатай тохиолдолд хувьчлалын талаар санал гаргаж зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;

3.9. Нийтийн халуун усны газрыг зориулалтыг нь өөрчлөхгүй байх нөхцөлтэйгээр тухайн орон нутгийн онцлогт тохируулан төсөл сонгон шалгаруулах аргаар хувьчлах буюу түрээслүүлэх;

3.10. Хувийн хөрөнгө оруулалтаар хог боловсруулах үйлдвэр, нийтийн халуун ус шинээр барьж тэдгээрийн ашиглалт үйлчилгээг хариуцах үйл ажиллагаанд төрөөс зохих журмын дагуу дэмжлэг үзүүлэх;

3.11. Хот суурин газрын хог хаягдал, хот тохижилт, төвлөрсөн системд холбогдоогүй ус түгээх байр болон ус зөөврийн үйлчилгээг зориулалтыг нь өөрчлөхгүй байх нөхцөлтэйгээр төсөл сонгон шалгаруулах аргаар хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлэх, хувьчлах, түрээслүүлэх;

3.12. Шинээр баригдаж байгаа орон сууцны хотхон, хороолол, цогцолборын инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалт, засварыг уг үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хувийн хэвшлийн мэргэжлийн байгууллагаар төсөл сонгон шалгаруулан гүйцэтгүүлэх, хөрөнгө оруулалт хийлгэх, түрээсээр ашиглуулах замаар хувийн хэвшлийн оролцоог дэмжих;

3.13. Хот суурин газрын инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй захын хорооллын хэрэглэгчдэд зориулж хувийн хэвшлийн хөрөнгө оруулагч өөрийн хөрөнгөөр нийтийн аж ахуйн үйлчилгээний инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийг "барих, ашиглах, шилжүүлэх", эсхүл үндсэн сүлжээг эзэмшигчдэд түрээсээр ашиглуулах, тодорхой хугацааны дараа оруулсан хөрөнгөө нөхөн авах зэрэг хөрөнгө оруулалтын хэлбэрийг ашиглаж нийтийн аж ахуйн салбарын техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, шинээр барьж байгуулах асуудлыг зохих хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;

3.14. Эрх зүйн орчинг бүрдүүлэх замаар төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний үнэ тарифыг боловсронгуй болгох, нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагыг үр ашигтай ажиллуулах нөхцөл бүрдүүлэх үүрэг бүхий бие даасан зохицуулалтын тогтолцоог бий болгох;

3.15. Ус хангамж, ариутгах татуургын үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, байгууллагын зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх;

3.16. Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын хувьчлал, өөрчлөн байгуулалтыг энэхүү чиглэлийг баримтлан 2008-2012 онд хэрэгжүүлэх.

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээ

4.1. Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын аж ахуйн нэгж, байгууллагыг хувьчлах, өөрчлөн байгуулах ажлыг тухайн орон нутгийн онцлогт тохируулан нийтийн аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Төрийн өмчийн хороо, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хамтран хэрэгжилтийг зохих хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна.

4.2. Нийтийн аж ахуйн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь нийтийн аж ахуйн инженерийн барилга байгууламжийн технологийн горим, ашиглалт, үйлчилгээг сайжруулах чиглэлээр дэмжлэг үзүүлж, мэргэжлийн удирдлагаар хангана.

4.3. Төрийн өмчийн хороо нь хувьчлах чиглэлийг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавина.

4.4. Аймаг, нийслэлийн Засаг дарга холбогдох газруудтай хамтран энэхүү чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулж, нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагын үйлчилгээний чанарын түвшин, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авна.

4.5. Энэхүү чиглэлийн хэрэгжилтийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг нийтийн аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар эрхлэн гүйцэтгэнэ.

Тав. Шалгуур үзүүлэлт

5.1. Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагын санхүү, эдийн засгийн үзүүлэлт дээшилж, өр авлагын хэмжээ буурсан байх.

5.2. Хот суурин газрын хүн амын 30-аас доошгүй хувь нь төвлөрсөн ус хангамжийн системд холбогдсон байх.

5.3. Орчин үеийн дэвшилтэт техник, технологийн нэвтрүүлснээр нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагын ажил үйлчилгээний төрөл, тоо хэмжээ, чанарын үзүүлэлт сайжирсан байх.

5.4. Бохир ус цэвэрлэгээний түвшин нь стандартын шаардлага хангаж, байгаль орчин, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан байх.

Зургаа. Хүрэх түвшин

6.1. Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагын бүтэц, зохион байгуулалт боловсронгуй болж, хөрөнгийн ашиглалт сайжирч, эдийн засгийн үр ашиг дээшилнэ.

6.2. Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарт хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэж, өрсөлдөөн бий болсноор үйлчилгээний чанар, хүртээмж дээшлэн хүн амын ажиллаж, амьдрах таатай нөхцөл бүрдэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 183

Улаанбаатар хот

Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Транзит Монгол" үндэсний хөтөлбөрийг 1 дүгээр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохицуулж ажиллахыг Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Р.Рашид үүрэг болгосугай.

3. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улс, орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж уг хөтөлбөрийн ач холбогдлыг олон улсын байгууллага, хандивлагч орнуудад таниулах, тэдгээрийг зээл, тусламжид

хамруулах арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Ч.Улаан, Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Р.Рашид, Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүү нарт даалгасугай.

4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Р.Рашид үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Р.РАШИД

**Засгийн газрын 2008 оны 183 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт**

"ТРАНЗИТ МОНГОЛ" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг, Нийтлэг үндэслэл

1. Оршил

Даяарчлалын өнөө үед Монгол Улс газар зүйн байрлалын давуу талаа ашиглан олон улсын худалдаа, тээвэр, логистикийн нэгдсэн сүлжээний бүрэлдэхүүн хэсэг болох замаар транзит орон болсноор олон улсын худалдаа, тээвэр, логистикийн зах зээлд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх, улмаар эдийн засгийн өсөлтийг хурдасгах, эдийн засаг, нийгмийн тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой юм.

2. Худалдаа, тээврийг хөнгөвчлөх тухай ойлголт

НҮБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн нийгэм, эдийн засгийн комиссоос гаргасан зөвлөмжид тодорхойлсноор "Худалдааг хөнгөвчлөх" гэдэгт барааны экспорт, импорт болон транзит урсгалыг аль болох хямд, хурдан шуурхай, чөлөөтэй нэвтэрч байх орчин бүрдүүлэх үйл ажиллагааг ойлгодог байна.

Бараа бүтээгдэхүүний хөдөлгөөнд Засгийн газрын зохицуулалт, улсын хил, гааль, хяналтын байгууллагын үйлчилгээний чанар, бизнесийн ур чадвар, тээвэрлэлт, тээврийн дэд бүтэц, харилцаа холбооны чадавхи, санхүүжилт зэрэг олон хүчин зүйл шууд нөлөөлж байдаг.

"Тээврийг хөнгөвчлөх" гэдэг ойлголт нь худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагааны салшгүй хэсэг бөгөөд зорчигч болон ачааг тээвэрлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох, тээвэрлэлтийн саад тогторыг арилгах, дэд бүтцийг бий болгох цогц үйл ажиллагаагаар тодорхойлогдох болно.

3. Хөтөлбөрийн үндэслэл, шаардлага

Транзит тээвэр, логистикийг хөгжүүлэх нь худалдаа, тээвэр, хил хамгаалах, гааль, мэргэжлийн хяналт зэрэг олон салбарын нэгдмэл хамтын ажиллагаа болон хувийн хэвшил, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудын идэвхтэй оролцоо шаардсан өргөн хүрээтэй цогц үйл ажиллагаа юм.

Монгол Улсын хувьд худалдаа, тээврийг хөнгөвчлөх чиглэлээр нэгдсэн бодлого, зохицуулалт, дэд бүтэц, техникийн хүчин чадал хангалтгүй, эрх зүйн зохицуулалт бүрдээгүй байгаа болно.

Одоогоор Монголын транзит тээвэрт төмөр зам гол үүрэг гүйцэтгэж байна. Сүүлийн жилүүдэд Монгол Улсын эдийн засаг эрчимтэй өсч, гадаад, дотоод худалдааны хэмжээ нэмэгдэж, энэхүү эрэлтийг хангахад тээврийн дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, техник хэрэгслийн хүчин чадлыг эрс сайжруулах шаардлагатай болж байна.

Хил, гаалийн хяналт шалгалт, удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн чадавхи, техник

технологи нь олон улсын түвшин, стандартын нөхцөл шаардлагыг бүрэн хангаагүй, хөрш орнуудын хил, гаалийн байгууллагуудтай ажлын уялдаа холбоо сул байгаа нь тарифын бус хүндрэлийг үүсгэсээр байна.

Монгол Улсын хөдөө аж ахуй, уул уурхай болон бусад салбарын үйлдвэрлэл үйлчилгээнд тээвэр логистикийн төвүүд ашиглагдахгүй байгаагаас үйлдвэр, аж ахуйн газрууд өөрийн хэрэгцээний тоног төхөөрөмж, түүхий эдийг олж авах, бараа үйлчилгээг борлуулах, экспортлоход ихээхэн нэмэлт зардал гарч байна.

Монгол Улсын үндэсний стандартын нөхцөл шаардлага тодорхой бус, хуучирсан, зарим шаардлагатай стандартууд байхгүй, мэргэжлийн хяналтын үзлэг хийх техник, технологийн бололцоо хангалтгүй байгаа нь импортын бараанд хяналт тавих боломжийг хязгаарлаж байна.

Монгол Улсад үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээний стандарт, гарал үүслийн гэрчилгээг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөхүйц баталгаажуулах үндэсний лаборатори байхгүйгээс Монголын экспортын барааг олон улсын зах зээлд нийлүүлэх асуудал хүндрэлтэй хэвээр байна. Бүс нутгийн худалдаа өсөхийн хэрээр олон улсын тээвэр, логистикийн салбар дахь өрсөлдөөн улам нэмэгдэж байхад Монгол Улсын тээвэр, логистикийн салбарын хөгжил олон улсын худалдаа, тээврийн зах зээлийн хөгжлөөс хоцорч байгаагаас транзит тээвэр өсөхгүй байна.

Худалдаа, тээврийн салбарын мэдээ, мэдээлэл, хэрэгжсэн төсөл арга хэмжээ, дотоодын болон гадаад зах зээлийн судалгаа, олон улсын чиг хандлагатай уялдуулан Монгол орны нөхцөлд худалдаа, тээврийг хөгжүүлэх боломжийг судлан энэхүү хөтөлбөрийг боловсруулав.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, үйл ажиллагаа, хамрах хүрээ

4. Хөтөлбөрийн зорилго, зорилт

Хөтөлбөрийн үндсэн зорилго нь Монгол Улс өөрийн газар зүйн байрлалын давуу талыг ашиглан, зах зээлийн бодит хэрэгцээнд суурилсан, хувийн хэвшил, гадаадын хөрөнгө оруулагчдын идэвхтэй оролцоотой транзит тээвэр, логистикийн салбарыг дэмжин хөгжүүлэхэд чиглэгдэнэ. Энэхүү зорилгыг дараахь зорилтуудын хүрээнд хэрэгжүүлнэ:

4.1. Гадаад худалдаа, олон улсын тээвэр, логистикийн үйлчилгээний эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

4.2. Худалдаа, тээвэр, логистикийн үйлчилгээг хөггөвчлөх, дэмжин хөгжүүлэх;

4.3. Үндэсний зам, тээврийн сүлжээг өргөжүүлж, олон улсын тээврийн системтэй холбох;

4.4. Олон улсын транзит тээврийг дэмжих;

4.5. Улсын хил, гааль, мэргэжлийн хяналтыг хөнгөвчлөх, үр нөлөөг сайжруулах;

4.6. Худалдаа, тээвэр, логистикийн үйлчилгээг хөнгөвчлөхөд мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг нэвтрүүлэх;

4.7. Худалдаа тээвэр логистикийн салбарын бүтэц, зохион байгуулалтыг шинэчилж, хүний нөөцийн удирдлагыг боловсронгуй болгох.

5. Үйл ажиллагаа

Дэвшүүлсэн зорилтуудыг дараахь үйл ажиллагаагаар хэрэгжүүлнэ:

5.1. Гадаад худалдаа, олон улсын тээвэр, логистикийн үйлчилгээний эрх зүйн орчинг боловсронгуй болгох, сайжруулах зорилтын хүрээнд:

5.1.1. худалдаа, тээврийг хөнгөвчлөх, тээвэр зуучлал, тээвэр-логистикийн олон улсын гэрээ хэлэлцээрт ногдэн орж, үндэсний эрх зүйн орчинг түүнд нийцүүлэх;

5.1.2. авто тээвэр, иргэний нисэх, төмөр зам, усан замын тээврийн талаархи хуулиудад транзит тээвэр, логистикийн асуудлыг тусгах арга хэмжээг авах;

5.1.3. олон улсын болон транзит тээвэрлэлт, логистикийн үйл ажиллагааг улсын хил, гаалийн хяналттай уялдуулсан эрх зүйн зохицуулалт бий болгох;

5.1.4. олон улсын болон бүс нутгийн байгууллагуудын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, техник, арга зүйн зөвлөгөө, тусламж дэмжлэгийг нь ашиглах;

5.1.5. хөрш болон зэргэлдээ улс орнуудтай гэрээ хэлэлцээ байгуулах зэрэг арга хэлбэрээр худалдаа, тээврийг хөнгөвчлөх нөхцөлийг бүрдүүлэх;

5.1.6. худалдаа, тээвэр, логистикийн салбарын төрийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн идэвхтэй оролцоог хангах.

5.2. Худалдаа, тээвэр, логистикийн үйлчилгээг хөнгөвчлөх, дэмжин хөгжүүлэх зорилтын хүрээнд:

5.2.1. гадаад худалдааны бичиг баримтыг олон улсын жишигт нийцүүлэн нэг стандартад шилжүүлэх арга хэмжээ авах;

5.2.2. гадаад болон дотоод худалдаанд барааны зураасан кодын тогтолцоог нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

5.2.3. гаалийн үйлчилгээнд барааг "агуулахаас агуулахад" шилжүүлэхэд тавих хяналт, зохицуулалтын механизмыг нэвтрүүлэх;

5.2.4. Улаанбаатар хот орчимд улсын хэмжээний жишиг ачааны төрөлжсөн терминал аж ахуй, логистик төвүүд байгуулж, хотын хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан хүнс, өргөн хэрэглээний бараагаар хангах сүлжээг бий болгох;

5.2.5. Замын-Үүд, Улаанбаатарт дээд зэрэглэлийн логистик төв, терминал аж ахуйн бүсийн төвүүд болон бусад газарт В-С зэрэглэлийн логистик төв, терминал аж ахуйг байгуулж үндэсний нэгдсэн сүлжээ бий болгох;

5.2.6. Алтанбулаг, Цагааннуурын худалдааны чөлөөт бүс, Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүсийн үйл ажиллагааг худалдаа, тээврийн логистик төв, терминал аж ахуйн үйл ажиллагаатай уялдуулах;

5.2.7. Улаанбаатар хотод баригдах олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг түшиглэн төмөр зам, авто зам, агаарын тээврийн олон улсын сүлжээний HUB байгуулах;

5.2.8. Улаанбаатар, Хонхор, Замын-Үүд, Сүхбаатар өртөөнд олон улсын жишигт нийцсэн тээсэрч дэлбэрэх болон химийн бодисыг ачиж, буулгах тусгайлсан цэг, хураагдсан тээсэрч дэлбэрэх болон химийн бодисыг хадгалах түр агуулах байгуулах;

5.2.9. бүх төрлийн тээврийн хөдлөх бүрэлдэхүүний паркийг шинэчлэн нэмэгдүүлэх, ялангуяа төмөр замын тээврийн хөдлөх бүрэлдэхүүний паркийг түргэн гэмтэх, эмзэг бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн горимд нийцсэн тусгай зориулалтын вагоноор шинэчлэх;

5.3. Үндэсний зам, тээврийн сүлжээг өргөжүүлж, олон улсын тээврийн системтэй холбох зорилтын хүрээнд:

5.3.1. босоо тэнхлэгийн АН-3 авто замын Улаанбаатар хотыг тойрон өнгөрөх маршрутыг тодорхойлж, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, зам барилгын ажлыг гүйцэтгэх;

5.3.2. Чойр-Замын-Үүдийн авто замыг ашиглалтад оруулах;

5.3.3. хэвтээ тэнхлэгийн АН-32 авто замыг барьж дуусгах;

5.3.4. бүсийн тулгуур төв, аймгийн төвүүдийг хатуу хучилттай авто замаар холбох;

5.3.5. Баруун бүсийн босоо тэнхлэгийн АН-4 авто замыг ашиглалтад оруулж, замын дагуух аймгийн төвүүдийг хөрш орнуудын дэд бүтэц, логистикийн сүлжээ, терминал аж ахуйнуудтай холбох;

5.3.6. үндсэн төмөр замтай зэрэгцээ хоёрдох төмөр замыг барьж, транзит тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлэх;

5.3.7. төмөр замыг цахилгаанжуулах боломжийг судлах;

5.3.8. Зүүн болон хойн бүсийн төмөр замын үндсэн сүлжээг барьснаар бүрш болон Зүүн өмнөд Азийн орнуудтай худалдааны харилцааг өргөжүүлэх, нефть болон стратегийн бусад түүхий эдээр хангах боломжийг бүрдүүлэх арга хэмжээ авах.

5.4. Олон улсын транзит тээврийг дэмжих зорилтын хүрээнд:

5.4.1. Замын-Үүд-Улаанбаатар-Алтанбулаг маршрутаар авто тээврийн улс хоорондын транзит болон чингэлгийн тээвэрлэлт гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх;

5.4.2. улс хоорондын авто тээврийн чиглэлийн дагуу 150-200 км тутамд үйлчилгээний цогц дэд бүтэц (замын буудал, автомашины зогсоол, талбай, авто сервис, шатахуун түгээх станц, цайны газар, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хяналтын цэг, техникийн түргэн тусламж, нийтийн бие засах газрын үйлчилгээ) бий болгож, олон улсын стандартын түвшинд хүргэх;

5.4.3. ТИР карней ашиглан олон улсын хэмжээнд тээвэрлэлт гүйцэтгэхэд эрх зүйн, техник технологийн дэмжлэг үзүүлэх;

5.4.4. БНХАУ, ОХУ болон Ази, Европын орнуудын тээвэр зуучийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, бизнес уулзалт тогтмол зохион байгуулж, худалдаа, тээврийн логистикийн хөгжлийн "Транзит Монгол" Үндэсний хөтөлбөрийг танилцуулах, сурталчлах ажлыг зохион байгуулах;

5.4.5. Ази-Европын холбосон "Найрамдал", "Монгол вектор" чингэлгийн тээврийн цуваа зэрэг тээвэр зуучийн үйлчилгээний төсөл, арга хэмжээг дэмжих, өргөжүүлэн хөгжүүлэх арга хэмжээг авах;

5.4.6. монголын авто тээвэрчид БНХАУ-ын нутаг дэвсгэрээр дамжин далайн боомтод хүрэх, буцаж тээвэрлэлт гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх арга хэмжээг авах;

5.4.7. төмөр замын одоогийн хүчин чадлын хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрээр хийгдэх транзит тээврийг нэмэгдүүлэх, уг тээвэрлэлтийг гүйцэтгэхэд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, түншлэлийг дэмжин хөгжүүлэх.

5.5. Улсын хил дээрх гааль, мэргэжлийн хяналтыг хөнгөвчлөх, үр нөлөөг сайжруулах зорилтын хүрээнд:

5.5.1. улсын хил, гааль, мэргэжлийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг хангах, мэдээлэл харилцах солилцох, хялбарчилсан хяналт тавих удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авах;

5.5.2. хилийн мэргэжлийн хяналтын бүтэц, зохион байгуулалт, хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, лаборатори, техник тоног төхөөрөмж болон хүний нөөцийн чадавхийг олон улсын түвшинд хүргэх;

5.5.3. гаалийн бүрдүүлэлт, хяналт шалгалтад эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах, хамрах хүрээг өргөжүүлэх;

5.5.4. Замын-Үүд, Сүхбаатар боомтод вагон шалгах, Сүхбаатар боомтод чингэлэг шалгах рентген төхөөрөмж суурилуулах;

5.5.5. хориотой болон чанаргүй бараа бүтээгдэхүүн, аюултай хог хаягдлыг Монгол Улсын хилээр нэвтрэхээс сэргийлэх хяналт шалгалтыг шуурхай гүйцэтгэх орчин үеийн шинэ техник технологи нэвтрүүлэх;

5.5.6. тэсэрч дэлбэрэх болон химийн бодисыг төмөр замаар тээвэрлэх зориулалт бүхий вагон ашиглах.

5.6. Худалдаа, тээвэр, логистикийн үйлчилгээг хөнгөвчлөхөд мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг нэвтрүүлэх зорилтын хүрээнд:

5.6.1. гадаад худалдааны цахим бичиг баримтыг мэдээллийн сүлжээгээр дамжуулах, солилцох системийг бий болгоход төрийн холбогдох байгууллагуудын хүлээх үүргийг тодорхой болгож, үйл ажиллагааг нь уялдуулах замаар худалдаа, тээврийн баримт бичгийн бүрдүүлэлтийг хялбаршуулах;

5.6.2. худалдаа, тээврийн бичиг баримтад агуулагдах мэдээ, мэдээллийг хялбарчлах, нэг стандартад оруулах, цахим хэлбэрт шилжүүлэх;

5.6.3. гадаад худалдааны нэг цонхны электрон үйлчилгээг нэвтрүүлэх;

5.6.4. худалдаа, тээврийг хөнгөвчлөх Үндэсний хорооны вэб сайтаар дамжуулан холбогдох мэдээллийг монгол, англи болон бусад хэл дээр түгээх, төрийн болон хувийн хэвшлийн харилцах холбоо, хамтран ажиллах таатай орчинг бүрдүүлэх.

5.7. Худалдаа, тээвэр, логистикийн салбарын бүтэц, зохион байгуулалтын шинэчлэл, хүний нөөцийн удирдлагыг боловсронгуй болгох зорилтын хүрээнд:

5.7.1. худалдаа, тээвэр, логистикийн салбарын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын удирдлага, хүний нөөцийн чадавхийг сайжруулах;

5.7.2. төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулан, худалдаа, тээвэр, логистикийн салбарын цаг үеийн болон техник, технологийн дэвшлийн талаархи мэдээллийг нийтэд түгээх, олон нийтийн санал хүлээн авах тогтолцоог бүрдүүлэх;

5.7.3. төрийн болон хувийн хэвшлийн худалдаа, тээвэр, логистикийн салбарын ажилтныг хамруулсан мэргэжил дээшлүүлэх сургалт, олон улсын туршлага судлах, хурал, семинар зохион байгуулах;

5.7.4. олон улсын туршлагатай зөвлөх, шинжээч урьж ажиллуулах, мэргэжилтэн солилцох;

5.7.5. салбарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих, байнгын ажиллагаатай олон улсын судалгааны төв байгуулах, судалгаа, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэхэд хэрэглэж хэвших;

5.7.6. худалдаа, тээвэр, логистикийн салбарын бодлого, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, үйл ажиллагааны талаархи мэдээллээр олон нийтийг хангах.

6. Хөтөлбөрийн хамрах хүрээ

6.1. Худалдаа, тээврийг хөнгөвчлөх "Транзит Монгол" хөтөлбөрт дараахь төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж хамрагдана.

6.1.1. төрийн байгууллага:

зам, тээвэр, үйлдвэр худалдаа, гадаад хэрэг, санхүү, хууль зүй, дотоод хэргийн асуудал



хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, авто тээвэр, авто зам, төмөр зам, иргэний нисэх, усан зам, улсын хил, гааль, мэргэжлийн хяналт, мэдээлэл, харилцаа холбооны технологийн асуудал хариуцсан Засгийн газрын агентлаг, байгууллага, тэдгээрийн орон нутаг дахь салбар, харьяа байгууллага, лабораториуд

6.1.2. төрийн бус байгууллагууд:

Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Монголын авто тээвэрчдийн нэгдсэн холбоо, Монголын тээвэр зуучийн холбоо зэрэг холбогдох төрийн бус байгууллага.

6.1.3. аж ахуйн нэгж:

экспорт, импорт, дамжин өнгөрөх худалдаа, тээвэр, тээвэр зуучлал, лабораторийн шинжилгээ, логистикийн үйл ажиллагааг эрхэлдэг аж ахуйн нэгж болон бусад холбогдох аж ахуйн нэгж.

Гурав Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, зарчим

7. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

"Транзит Монгол" хөтөлбөрийг 2 үе шаттай хэрэгжүүлнэ.

Нэгдүгээр үе шат. Худалдаа, тээврийг хөнгөөчлөх, тээвэр логистикийн сүлжээ байгуулах бэлтгэл ажил (2008-2011 он) Энэ шатанд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

-Монгол Улсыг Транзит улс болгоход шаардлагатай олон улсын стандартуудыг судлан мөрдүүлэх арга хэмжээ авч, эрх зүй, дэд бүтэц, бизнесийн таатай орчинг бүрдүүлнэ.

-Гаалийн үзлэг хяналтад цахим нэг цооног үйлчилгээ болон "агуулахаас агуулахад" үзлэг хийх үйлчилгээг нэвтрүүлнэ;

-Тарифын болон тарифын бус бусад саад тогтооргыг арилгах замаар гадаад худалдаа, тээврийг хөнгөөчилж, транзит тээвэр, логистикийн салбарын Монгол Улсын эдийн засагт үзүүлэх нөлөөг нэмэгдүүлнэ.

-Төмөр зам голлосон бусад төрлийн тээврийн төрлүүд хосолсон "мультимодал" тээврийг хөгжүүлэх эхлэл тавигдана.

-Логистикийн салбарын хувьд томоохон хилийн боомтууд дээр дээд зэрэглэлийн логистикийн төвийг байгуулна.

-Хяналт-шинжилгээний лабораториудыг байгуулах ажлыг эхлүүлнэ.

-Худалдааны чөлөөт бүсийн үйл ажиллагааг логистикийн төв терминал аж ахуйн үйл ажиллагаатай уялдуулах эхлэл тавигдана.

Хоёрдугаар үе шат. Үйл ажиллагааг жигдрүүлж, олон улсын нэгдмэл сүлжээний

бүрэлдэхүүн хэсэг болгох. (2012-2015 он) Энэхүү шатанд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

-Монгол Улсад транзит тээвэр, логистикийн салбарын эрх зүй, дэд бүтэц, бизнесийн орчин олон улсын жишгийн хэмжээнд бүрдсэн байна.

-Гаалийн үзлэг хяналтад цахим нэг цооног үйлчилгээ, болон "агуулахаас агуулахад" үзлэг хийх үйлчилгээг нэвтрэн хэвшсэн байна.

-Тарифын болон тарифын бус бусад саад буурч худалдаа, тээвэр, логистикийн салбар олон улсын хэмжээнд өрсөлдөхүйц хэмжээнд хүрсэн байна. Транзит тээвэр, логистикийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлд эзлэх хувь 11.5 хувьд хүрнэ;

-Транзит тээврийн үйлчилгээг Монголын төдийгүй гадаад орнуудын нутаг дэвсгэр дээр төмөр зам, авто зам, агаарын тээвэр нь дангаар болон мультимодал хэлбэрээр үзүүлнэ.

-Барааг багцлах, захиалга авах, савлах, хаяглах, зарим боловсруулалт хийх зэргээр бараа, үйлчилгээнд нэмэгдсэн өртөг шингээсэн үйлчилгээг үзүүлэх логистикийн төв терминал аж ахуйнууд байгуулагдан үйл ажиллагаа нь тогтворжсон байна;

-Хяналт-шинжилгээний лабораториудыг байгуулах ажлыг үргэлжлүүлнэ.

-Худалдаа болон эдийн засгийн чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг логистик төв терминал аж ахуйн үйл ажиллагаатай уялдуулан жигдрүүлнэ;

-Далайд гарцгүй орнуудын худалдаа, тээвэр, логистикийн салбарын хөгжил, чиг хандлага, бодлого, үйл ажиллагааны хэрэгцээ, тэдгээрийн нөлөөг судлах, бодлого үйл ажиллагааны зөвлөмж санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий олон улсын судалгааны төв байгуулах үндэс суурь тавигдсан байна.

8. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараахь зарчмыг баримтална.

8.1. Монгол Улсын худалдаа, тээвэр, логистикийн салбар нь олон улсын нэгдсэн сүлжээний бүрэлдэхүүн хэсэг байх.

8.2. Худалдаа, тээвэр, логистикийн салбарын хөгжлийн бодлого нь Монгол Улсын Үндэсний хөгжлийн цогц бодлоготой нягт уялдан байх.

8.3. Худалдаа, тээвэр, логистикийн салбарыг хөгжүүлэх арга хэмжээг иргэд, хувийн хэвшил, төрийн болон төрийн бус байгууллагууд хамтын үйл ажиллагаанд тулгуурлан зохион байгуулж хэрэгжүүлэх.

8.4. Худалдаа, тээвэр, логистикийн хөгжүүлэх үйл ажиллагаа нь олон улсын

байгууллагаас баримталж байгаа бодлого, чиглэлтэй нийцсэн байх бөгөөд тэдгээр байгууллагатай хамтран ажиллах.

9. Хөтөлбөрийн санхүүжилт

9.1. Хөтөлбөрийг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

9.1.1. улсын болон орон нутгийн төсөв, сангаас зам, дэд бүтэц бусад улс орны бүтээн байгуулалтын ажилд зориулж хуваарилсан хөрөнгө оруулалт;

9.1.2. олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын зээл, тусламж;

9.1.3. дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалт;

9.1.4. хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, бусад.

Дөрөв. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

10. Хөтөлбөрийг дараахь байдлаар удирдан, зохион байгуулна:

10.1. Монгол Улсын хэмжээнд "Транзит Монгол" хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, хяналт үнэлгээ өгөх үүрэг бүхий нэгжийг Худалдаа, тээврийг хөнгөвчлөх Үндэсний хорооны дарга удирдана;

10.2. Орон нутагт хөтөлбөрийн хэрэгжилтийг аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцна.

Тав. Үр дүн

11. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр Монгол Улсын эдийн засгийн бүтэц, бодлогод дараахь өөрчлөлт гарна:

11.1. Дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлд транзит тээвэр, логистикийн салбарын эзлэх хувь нэмэгдсэнээр, байгалийн баялаг, эрдэс бодисын үнийн хэлбэлзлээс хамааралтай эдийн засаг, бизнесийн тогтворгүй байдал бий болох магадлал багасна;

11.2. Шавхагдах нөөцтэй уул уурхайн салбараас хэт хамааралтай эдийн засгийн бүтэцэд техник технологи, хүний нөөцийн чадавхи, олон улсын худалдааны өсөлттэй холбогдуулан хөгжүүлэх боломж бүхий худалдаа, тээвэр, логистикийн шинэ салбарын гүйцэтгэх үүрэг нэмэгдэнэ;

11.3. Олон улсын худалдаа, тээвэр, логистикийн нэгдсэн сүлжээний чухал бүрэлдэхүүн хэсэг болсноор олон улсын худалдаа, тээврийн зах зээлд Монгол Улсын олон улсын худалдаа, тээврийн зах зээлд эзлэх байр суурь, үзүүлэх нөлөө дээшилнэ;

11.4. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх боломж нэмэгдэнэ;

11.5. Тодорхой газрууд (бүсийн тулгуур төв, худалдаа, эдийн засгийн чөлөөт бүс) эдийн засгийн идэвхтэй эргэлтэд орно;

11.6. Транзит тээвэр, логистикийн салбарыг дагаж хөгжих үйлчилгээний салбарын тоо нэмэгдэж, тэдгээрт ажиллагсдын орлого нэмэгдэнэ;

11.7. Транзит тээвэр, логистикийн салбараас төсөвт оруулах татварын хувь хэмжээ нэмэгдэнэ.

Зургаа. Шалгуур үзүүлэлт, нөлөө

12. Үр дүнгийн шалгуур үзүүлэлт

12.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ:

Д/д	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт (2007 он)	Эхний шатны зорилт (2012 он)	Хөтөлбөрийн зорилт (2015 он)
1	ДНБ-д тээвэр логистикийн салбарын эзлэх хувь	9.6	11.2	11.5
2	Олон улсын нэгдсэн сүлжээнд хамрагдсан авто замын урт (км)	1348	2877	4116
3	Төмөр замын дамжин өнгөрөх тээврийн ачааны хэмжээ (сая тн)	3.5	9.0	16.0
4	Авто тээврийн дамжин өнгөрөх ачааны хэмжээ (сая тн)	0	0.5	2.5
5	Дээд зэрэглэлийн логистик төвүүдийн тоо	0	1	2
6	Монгол Улсын нутгаар ачааны галт тэрэг дамжин өнгөрөх дундаж хугацаа (цаг)			
	-Сүхбаатар-Эрээний чиглэлд	56	32	16
	-Эрээн-Сүхбаатарын чиглэлд	72	36	18

Засгийн газрын 2008 оны 183 дугаар
 тогтоолын 2 дугаар хэсгэрлэл

"ТРАНЗИТ МОНГОЛ" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/А	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Санхүүжилтийн хэмжээ (сая ам.дол)	Санхүүжилтийн хэлбэр	Хариуцаа байгууллага
	1. Гадаад худалдаа, олон улсын тээвэр, логистикийн үйлчилгээний эрх зүйн орчинг боловсронгуй болгох				
1.1	Олон улсын конвенци, гэрээ хэлэлцээрүүдийг судлах, нэгдэн орох хэрэгцээ шаардлагыг тооцох	2008-2009	-	-	ГХЯ, ХЗДХЯ, ЗТАЖЯ, УХЯ, Худалдаа, тээврийг хөгвөчлөх үндэсний хороо
1.2	Конвенци, гэрээ, хэлэлцээрүүдэд нэгдэн орох үйл ажиллагааг зохион байгуулах	2008-2012	-	Холбогдох төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны зардал	ГХЯ, ХЗДХЯ, ЗТАЖЯ, УХЯ, Худалдаа, тээврийг хөгвөчлөх үндэсний хороо
1.3	Үндэсний хууль тогтоомжуудыг нэгдэн орсон конвенци, гэрээ, хэлэлцээрүүдэд нийцүүлэн өөрчлөх	2008-2012	-	Холбогдох төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны зардал	ХЗДХЯ, ЗТАЖЯ, УХЯ, Худалдаа, тээврийг хөгвөчлөх үндэсний хороо
1.4	Авто тээвэр, иргэний нисэх, төмөр зам, усан дамжин тээврийн тухай хуулиудад тээвэр, логистикийн асуудлыг тусган оруулж шинэчлэх	2008-2010	-	Холбогдох төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны зардал	ХЗДХЯ, ЗТАЖЯ, УХЯ, Худалдаа, тээврийг хөгвөчлөх үндэсний хороо
1.5	Транзит тээвэрлэлт, логистикийн үйл ажиллагааг улсын хил, гаалийн хангалттай уялдуулан эрх зүйн зохицуулалт хийх дүрэм, журмыг боловсруулах	2008-2010	-	Холбогдох төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны зардал	Худалдаа, тээврийг хөгвөчлөх үндэсний хороо, Холбогдох яам, агентлагууд
1.6	Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын Засгийн газар хооронд байгуулах дамжин өнгөрөх тээврийн хэлэлцээрийг байгуулах (эсвэл түүнийг орлох бус нутгийн хэлэлцээрт нэгдэн орох)	2008-2009	-	Холбогдох төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны зардал	ГХЯ, ХЗДХЯ, ЗТАЖЯ, УХЯ, Худалдаа, тээврийг хөгвөчлөх үндэсний хороо, Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын Засгийн газар хооронд дамжин өнгөрөх тээврийн хэлэлцээрийн төслийг боловсруулж байгуулах ажлын хэсэг
1.7	Монголын тээвэрчид БНХАУ-ын нутаг дэвсгэрээр дамжин далайн боомтод хүрч тээвэр хийх асуудлыг хятадын талд тавих	2008-2012	-	Холбогдох төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны зардал	ГХЯ, ХЗДХЯ, ЗТАЖЯ, УХЯ, Худалдаа, тээврийг хөгвөчлөх үндэсний хороо
1.8	Олон улсын болон бус нутгийн байгууллагуудын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, Монгол Улсын байр суурийг бэхжүүлэх, харилцан ашигтай хамтран ажиллах	2008-2015	-	-	ГХЯ, ХЗДХЯ, ЗТАЖЯ, УХЯ, Худалдаа, тээврийг хөгвөчлөх үндэсний хороо
1.9	ОХУ-ыг Дэлхийн худалдааны байгууллагад элсэх, хөрс оруулахыг олон улсын байгууллага, конвенцид нэгдэхийг дэмжих замаар эрх зүйн нэгдсэн орчин, стандарттай болох	2008-2012	-	-	ГХЯ, ХЗДХЯ, ЗТАЖЯ, УХЯ, Худалдаа, тээврийг хөгвөчлөх үндэсний хороо
1.10	Салбарын бодлого боловсруулж хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн идэвхтэй оролцоог бий болгох хууль эрхийн актуудыг батлан мөрдүүлэх	2008-2012	-	-	ЗТАЖЯ, ХЗДХЯ, УХЯ
1.11	Шөвц төхник, технологи нэвтрүүлэх, хувийн хэвшлийн хөгжүүлэх, хувийн хэвшлийн мэргэжлийн сургуулидыг дэмжих бодлого арга хэмжээг авч хэрэгжүүлэх	2008-2012	-	-	ЗТАЖЯ, ХЗДХЯ, УХЯ, Худалдаа, тээврийг хөгвөчлөх үндэсний хороо

1.12	Ачааны тусгайсан (10 гаруй) болон тээвэр, худалдааны бусад стандартууд боловсруулж батлуулах	2008-2012	-	Холбогдох төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны зардал	ЗТАЖ, СХЗТ, ХЗДХЯ УХЯ, Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо
2.1	НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудаас гаргасан гадаад худалдаатай холбогдсон эрх зүйн актыг судалж ашиглах	2008-2009	0.01	Гадаадын тусламж	УГЕГ, ЗТАЖ, УХЯ, УМХГ, Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо
2.2	Монгол Улсад хэрэглэгдэж байгаа гадаад худалдааны бичиг баримтуудыг олон улсын жишигт нийцүүлэх, нэг стандартад шилжүүлэх	2008-2010	0.01	Улсын төсөв, гадаадын тусламж	УГЕГ, ЗТАЖ, УХЯ, Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо
2.3	Монгол Улсад зурвасан кодыг хэрэглэх, төхнийн нөхцөлийг судлах	2008-2009	0.005	Гадаадын тусламж, хувийн хэвшил	УХЯ, УГЕГ, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим
2.4	Зурвасан кодыг хэрэглэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авч суурилуулах, хэрэглэх	2008-2010	0.1	Гадаадын тусламж, хувийн хэвшил	УХЯ, УГЕГ, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим
2.5	Зурвасан кодын талаар Олон улсын холбогдох байгууллагуудаас гаргасан дүрэм, журам, тогтоолцоог орчуулж бэлтгэх, гарын авлага гаргах, аж ахуйн нэгж байгууллагуудад танилцуулах, сургалт семинар зохион байгуулах	2008-2009	0.1	Гадаадын тусламж, хувийн хэвшил	Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим
2.6	Хилийн боомтуудад цаашид байгуулагдах гаалийн бус, аж үйлдвэрийн парк, логистикийн төв, терминал аж ахуйнуудад зурвасан код хэвлэх, унших тоног төхөөрөмжийг худалдан авч суурилуулах, хэрэглэх				
2.7	Зурвасан кодыг экспорт, импортын барзаны урсгалыг хянах, тээвэр, логистикийн зарчим бүрдүүлэхэд ашиглах, хуваарилалтын сувгийн бүхий л цагуудад зурвасан код хэрэглэх ажлыг эхлүүлэн жигдрүүлэх	2008-2012	-	Гадаадын тусламж, хувийн хэвшил	УХЯ, УГЕГ, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим
2.8	Зурвасан кодыг худалдаа, тээвэр, логистикийн салбарт болон хуваарилалтын сувгийн бүх цагт хэрэглэх боломжийг бүрдүүлэх, электрон өгөгдөл солилцоо (EDI) болон холбогдох бусад мэдээлэл дамжуулах технологийн программ хангамжийг боловсруулах	2008-2012	0.1	Гадаадын тусламж, хувийн хэвшил	УХЯ, УГЕГ, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим СЯ МХХТГ
2.9	Баталгаан, Алтанбулаг, Цагааннуурт галийн баталгааг агуулахыг байгуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах	2008-2012	1.35	Улсын төсөв, гадаадын тусламж, хувийн хэвшил	УГЕГ, УМХГ, УХЯ, Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо
2.10	Цэрийн-Үүд, Алтанбулаг, Цагааннуурт хорио цэрийн байгууламж байгуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах	2008-2012	0.3	Улсын төсөв, гадаадын тусламж, хувийн хэвшил	СЯ, УМХГ, УХЯ
2.11	Улаанбаатар хот орчимд ачааны төрөлжсөн терминал аж ахуй, логистик төв байгуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах	2008-2009	0.65	Орон нутгийн төсөв, гадаадын тусламж, хувийн хэвшил	ЗТАЖ, УХЯ, УГЕГ, УМХГ, Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо, Олон улсын байгууллагууд

2.12	Улаанбаатар хот орчимд ачааны төрөлжсөн терминал аж ахуй, логистик төвийн зургаг төслийг боловсруулах, газрын асуудлыг шийдвэрлэх	2009-2011	0.2	Орон нутгийн төсөв, гадаадын тусламж, хувийн хэвшил	ЗТАЖЯ, УХЯ, УГЕГ Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо
2.13	Улаанбаатар хот орчимд ачааны төрөлжсөн терминал аж ахуй, логистик төв барих	2011-2014	18.0	Орон нутгийн төсөв, гадаадын тусламж, хувийн хэвшил	ЗТАЖЯ, УХЯ Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо
2.14	Улаанбаатарын орчимд ачааны төрөлжсөн терминал аж ахуй, логистик төвийг холбоон сүлжээг бий болгох	2010-2015	1.0	Орон нутгийн төсөв, гадаадын тусламж, хувийн хэвшил	Холбогдох яам, агентлагууд
2.15	Замын-Үүдэд дээд зэрэглэлийн логистик төв, терминал аж ахуй, ариутгал халдваргүйжүүлэлт болон хорго цэврийн байгууламж байгуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах	2008-2010	0.5	Улсын төсөв, гадаадын тусламж, хувийн хэвшил	ЗТАЖЯ, УГЕГ, УМХГ, ТЭХЭГ, УБТЗ
2.16	Замын-Үүдийн дээд зэрэглэлийн логистик төв, терминал аж ахуй байгуулах	2008-2011	20.0	Улсын төсөв, гадаадын тусламж, хувийн хэвшил	ЗТАЖЯ, УГЕГ, УМХГ, ТЭХЭГ, УБТЗ, Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо, Хувийн хэвшил, гадаадын хөрөнгө оруулалт
2.17	В-С зэрэглэлийн логистик төв, терминал аж ахуйг байгуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах	2009-2012	0.5	Улсын төсөв, гадаадын тусламж, хувийн хэвшил	ЗТАЖЯ, УГЕГ, ТЭХЭГ, УБТЗ, Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо
2.18	В-С зэрэглэлийн логистик төв, терминал аж ахуйг байгуулах	2009-2014	10.0	Улсын төсөв, гадаадын тусламж, хувийн хэвшил	ЗТАЖЯ, УГЕГ, ТЭХЭГ, УБТЗ, Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо, Хувийн хэвшил, гадаадын хөрөнгө оруулалт
2.19	Аптанбулагийн худалдааны чөлөөт бүсийн үйл ажиллагааг логистикийн төв, терминал аж ахуйн үйл ажиллагаатай уялдуулах	2008-2012	50.0	Гадаадын тусламж, хувийн хэвшил	УХЯ, УГЕГ, УМХГ, ХХЕГ
2.20	Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүсийн үйл ажиллагааг логистикийн төв, терминал аж ахуйн үйл ажиллагаатай уялдуулах	2008-2012	50.0	Гадаадын тусламж, хувийн хэвшил	УХЯ, УГЕГ, УМХГ, ХХЕГ
2.21	Ховд, Улиастай, Хархорин, Эрдэнэт, Чойбалсан, Өндөрхаанд ачааны терминал аж ахуй байгуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах	2010-2012	7.0	Улсын төсөв, гадаадын тусламж, хувийн хэвшил	УХЯ, УГЕГ, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо
2.22	Ховд, Улиастай, Хархорин, Эрдэнэт, Чойбалсан, Өндөрхаанд ачааны терминал аж ахуй байгуулах	2012-2015	30.0	Улсын төсөв, гадаадын тусламж, хувийн хэвшил	УМХГ, ХХЕГ, хувийн хэвшил, гадаадын хөрөнгө оруулалт
2.23	Улаанбаатар хотод баригдах олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг Тушиглан төмөр зам, авто зам, агаарын тээврийн олон улсын сүлжээний HUB байгуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах	2008-2011	1.5	Улсын төсөв, гадаадын тусламж, хувийн хэвшил	СЯ, ЗТАЖЯ Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо

2.24	Улаанбаатар хотод баригдах олон улсын шенген нисэх онгоцны буудлыг түшиглэн төмөр зам, авто зам, агарын тээврийн олон улсын сүлжээний НУВ байгуулах	2013-2015	200.0	Улсын төсөв, гадаадын зээл, тусламж, хувийн хэвшил	СЯ, ЗТАЖА Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо
2.25	Бүх төрлийн тээврийн хөдлөх бүрэлдэхүүний паркыг шинэчлэн нэмэгдүүлэх, ялангуяа төмөр замын тээврийн хөдлөх бүрэлдэхүүний паркыг түргэн гэмтэх, эмзэг бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн горимд нийцсэн тусгай зориулалтын вагоноор шинэчлэх	2008-2015	250.0	Улсын төсөв, гадаадын зээл, тусламж, хувийн хэвшил	СЯ, ЗТАЖА
3. Үндэсний зам, тээврийн сүлжээг өргөжүүлж, олон улсын тээврийн системтэй холбох					
3.1	Чойр-Замын-Үүдийн авто замыг ашиглалтад оруулах	2008	52.0	Улсын төсөв, гадаадын зээл, тусламж	СЯ, ЗТАЖА
3.2	Улаанбаатар хотыг тойрон өнгөрөх Яармагийн пүүр-Баранзүрхийн товчоо чиглэлийн авто замыг ашиглалтад оруулах	2009-2011	3.6	Улсын төсөвөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр (хувийн хэвшил), гадаадын зээл, тусламж	СЯ, ЗТАЖА Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо
3.3	АН-3 авто замыг ашиглалтад оруулах	2008-2011	132.0	Улсын төсөв, улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр (хувийн хэвшил), гадаадын зээл, тусламж	СЯ, ЗТАЖА
3.4	АН-32 авто замыг барьж дуусгах	2008-2015	150.0	Улсын төсөв, гадаадын зээл, тусламж, хувийн хэвшил	СЯ, ЗТАЖА
3.5	Улаанбаатар, Алтанбулаг, Замын-Үүдэд улс хоорондын зорчигч тээврийн авто вокзал байгуулах	2008-2018	2.5	Улсын төсөв, гадаадын зээл, тусламж, хувийн хэвшил	СЯ, ЗТАЖА
3.6	Бусийн төв, аймгийн төвүүдийг хатуу хучилттай авто замаар холбох	2008-2015	377.4	Улсын төсөв, гадаадын зээл, тусламж, хувийн хэвшил	СЯ, ЗТАЖА
3.7	Төмөр замын үндсэн сүлжээнд хөврдөх зам тавих асуудлыг судлан шийдвэрлэх	2008-2009	1200.0	Улсын төсөв, гадаадын зээл, тусламж	СЯ, ЗТАЖА
3.8	Төмөр замд цахилгаан галт тэрэг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах	2008-2010	20.0	Улсын төсөв, гадаадын зээл, тусламж	СЯ, ЗТАЖА, Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо
3.9	Төмөр замд цахилгаан галт тэрэг хэрэглэх төслийг хэрэгжүүлэх	2010-2015	1200.0	Улсын төсөв, гадаадын зээл, тусламж	СЯ, ЗТАЖА
3.10	Зүүн болон говийн бүсийн төмөр замын сүлжээг байгуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах	2008-2009	50.0	Улсын төсөв, гадаадын хөрөнгө оруулалт	СЯ, ЗТАЖА, ҮХЯ, Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо
3.11	Ярант-Ховд-Өлгий-Цагааннуур чиглэлийн АН-4 авто замыг барьж ашиглалтад оруулах	2008-2012	110.0	Улсын төсөв, гадаадын зээл, тусламж, хувийн хэвшил	СЯ, ЗТАЖА
4. Олон улсын транзит тээврийг дэмжих					
4.1	Замын-Үүд-Улаанбаатар-Алтанбулаг маршрутаар авто тээврийн улс хоорондын тээвэрлэлт хийх эрх зүйн орчинт болговсронгүй болгох, сайжруулах	2008-2010	-	-	ЗТАЖА, ХЗДХЯ, ГХЯ, УГЕГ, ХХЕГ

4.2	Замын-Үүд-Улаанбаатар-Алтанбулаг маршруттар авто тээврийн улс хоорондын чингэлгэн тээвэрлэлт нэвтрүүлэхэд шаардалагтай үйлчилгээний дэд бүтцийг бий болгох	2009-2012	75.0	Улсын төсөв, гадаадын зээл, тусламж, хувийн хэвшил, гадаадын хөрөнгө оруулалт	Холбогдох яам, агентлагууд
4.3	ГИР карнайн конвенци болон бусад худалдаа, тээврийг хөнгөвчлөхтэй холбогдсон олон улсын гэрээ хэлэлцээрийг хэрэгжүүлэх	2008-2015	-	-	ЗТАЖЯ, УГЕГ
4.4	БНХАУ, ОХУ болон Ази, Европын орнуудын тээвэр зүүчийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, бизнес уулзалтыг тогтмол зохион байгуулах	2008-2015	0.08	Гадаадын тусламж, хувийн хэвшил	ЗТАЖЯ, УХЯ, УГЕГ Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо
4.5	Үндэсний хөтөлбөрийг танилцуулах сургалчлах, үндэстэн Дамнасан корпорациудын анхаарлыг татах, хамтран ажиллах	2008-2015	0.16	Улсын төсөв, гадаадын тусламж	Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо
4.6	Ази-Европыг холбох тээврийн "Найрамдал", "Монгол вектор" чингэлгэн цуваа зэрэг хувийн хэвшлийн саначилга, эхлэлийг дэмжин өргөжүүлэх	2008-2015	0.2	Гадаадын тусламж, хувийн хэвшил	ЗТАЖЯ, Хувийн хэвшил
4.7	Далайн тээврийн хөлөг онгоцтой болох, далайн тээврийг хөгжүүлэхийг дэмжих	2010-2015	50.0	Гадаадын зээл, тусламж, хувийн хэвшил	ЗТАЖЯ, Хувийн хэвшил
4.8	Далайн баялаг ашиглах, далайн боомтын аж ахуйг ашиглахад дэмжлэг үзүүлэх	2010-2015	-	Гадаадын зээл, тусламж, хувийн хэвшил	ЗТАЖЯ
5. Улсын хил дээрх гааль, мэргэжлийн хяналтыг хөнгөвчлөх, үр нөлөөг сайжруулах					
5.1	Замын-Үүд, Сүхбаатар боомтод автон шалгах рентген төхөөрөмж суурилуулж ашиглалтад оруулах	2008-2010	6.0	Улсын төсөв, гадаадын зээл, тусламж	СЯ, УМХГ, УГЕГ
5.2	Сүхбаатар боомтод чингэлэг шалгах рентген төхөөрөмж суурилуулж ашиглалтад оруулах	2008-2009	3.0	Улсын төсөв, гадаадын зээл, тусламж	СЯ, УМХГ, УГЕГ
5.3	Улсын хилийн боомтуудад хяналт, шинжилгээний лаборатори байгуулах	2008-2010	0.5	Улсын төсөв, гадаадын зээл, тусламж	СЯ, УГЕГ, ЗТАЖЯ, УМХГ Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо
5.4	Улсын хилийн боомтуудад хяналт, шинжилгээний лаборатори байгуулах	2010-2015	10.0	Улсын төсөв, гадаадын зээл, тусламж	УГЕГ, УМХГ
5.5	Гэсгийн бүрдүүлэлт, хяналт шалгалтад эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгон сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх	2008-2015	0.2	Улсын төсөв, гадаадын тусламж	УМХГ, УГЕГ
5.6	Мэргэжлийн хяналт шалгалтад эрсдэлийн үнцэгээ хийх тогтолцоог бий болгож, сайжруулах арга хэмжээг авах	2008-2010	0.2	Улсын төсөв, гадаадын зээл, тусламж	УМХГ
6. Худалдаа, тээвэр, логистикийн үйлчилгээг хөнгөвчлөхөд мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг нэвтрүүлэх					
6.1	Гадаад худалдаанд цахим нэг цонхны үйлчилгээний системийг нэвтрүүлэх	2008-2012	5.0	Улсын төсөв, гадаадын тусламж, гадаадын хөрөнгө оруулалт	СЯ, УГЕГ, УХЯ

6.2	Худалдаа, тээврийн бичиг баримтад агуулагдах мэдээ, мэдээллийг хялбарчлах, нэг стандартад оруулах, цахим хэлбэрт шилжүүлэх	2008-2012	0.5	Улсын төсөв, гадаадын зээл, тусламж	УГЕГ, СЯ, ҮХЯ Үндэсний статистикийн хороо
6.3	Гадаад худалдааны мэдээ, бичиг баримтыг сүтгэжээж дамжуулах, солилцоо системийг бий болгож, холбогдох төрийн байгууллагуудын харьцах үүргийг тодорхойлох, үйл ажиллагааг нь уялдуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх	2008-2012	0.8	Улсын төсөв, гадаадын зээл, тусламж	Холбогдох яам, агентлагууд
6.4	Худалдаа, тээврийг хөнгөвчлөх Үндэсний хорооны веб сайтаар мэдээллийг монгол, англи болон бусад олон улсын хэл дээр түгээх, оролцож, талуудад хамтран ажиллах орчин бүрдүүлэх	2008-2015	0.2	Гадаадын тусламж	Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо МХХТТ
7. Худалдаа, тээвэр, логистикийн салбарын бүтэц, зохион байгуулалтын шинэчлэл, хүний нөөцийн удирдлагыг боловсруулж болгох					
7.1	Худалдаа, тээвэр, логистикийн салбарын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үүрэгтэй байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх	2008	0.2	Улсын төсөв, гадаадын тусламж	Холбогдох яам, агентлагууд, Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо
7.2	Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, цаг үеийн болон бодлого арга хэмжээний талаар санал мэдээлэл солилцох, хяналт үнэлгээ өгөх нэгдсэн бүтэц механизмьг бүрдүүлэх	2008-2009	-	-	Холбогдох яам, агентлагууд, Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо
7.3	Худалдаа, тээвэр, логистикийн салбар өндөр хөгжсөн орнуудад суралцацх аялал хийх, туршлага судлах	2008-2012	0.5	Улсын төсөв, гадаадын зээл, тусламж	СЯ, ЗТАЖЯ, ҮХЯ, УГЕГ Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо
7.4	Монголд олон улсын туршлага судлах, солилцох аялал, хурал өмнөмөр, зохион байгуулах	2008-2015	0.8	Гадаадын тусламж, хувийн хэвшил	Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо
7.5	Худалдаа, тээвэр, логистикийн салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, хүний нөөцийг чадваржуулах, энэ чиглэлийн сургалтын төвийг эрхлэн явуулах иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг дэмжих	2008-2012	-	-	БСШУЯ, НХХЯ Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо
7.6	Олон улсын туршлагатай авалэх, экспортуудийг урин ирүүлж урт, богино хугацаагаар ажиллуулж, мэргэжилтэн солилцох	2008-2015	0.8	Гадаадын тусламж	Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо
7.7	Олон улсын судалгааны төв байгуулах, судалгаа, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг бодлого, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжүүлэлтэд хэрэглэж хэвших	2008-2015	0.8	Улсын төсөв, гадаадын зээл, тусламж	Холбогдох яам, агентлагууд, Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо
7.8	Иргэдийг худалдаа, тээвэр, логистикийн салбар дахь төрийн бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээлэлээр хангах	2008-2015	0.2	Улсын төсөв, гадаадын зээл, тусламж	Холбогдох яам, агентлагууд, Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 184

Улаанбаатар хот

Чиглэл батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсыг хөгжүүлэх сангаас улсын эдийн засгийн чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг төлөвлөхөд 2009-2015 онд баримтлах чиглэлийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Ч.Улаанд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
С.БАЯР
САНГИЙН САЙД
Ч.УЛААН
Засгийн газрын 2008 оны 184 дүгээр тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАВХИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНХҮҮЖИЛТИЙГ ТӨЛӨВЛӨХӨД 2009-2015 ОНД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

Нэг. Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг төлөвлөхөд дараахь зарчмыг баримтална:

1. Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр улсын эдийн засгийн чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн, улсын хэмжээний томоохон арга хэмжээг санхүүжүүлнэ. Мянганы хөгжлийн зорилтод суурилсан "Үндэсний хөгжлийн цогц бодлого"-ыг хэрэгжүүлэхэд тэргүүлэх салбар болох боловсрол, эрүүл мэнд, эрчим хүч, зам, тээвэр, барилга, хүнс, хөдөө аж ахуйд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлснээр зорилтын шалгуурыг биелүүлж үр дүнд хүрсэн байна;

2. Монгол Улсыг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөхөд эхний ээлжинд байгууллагын чадавхи (техникийн ур чадвартай хүний нөөц, тоног төхөөрөмж болон тэдгээрийн хүчин чадал, материалын нөөц, ажлын туршлага)-ийн талаар Төсвийн ерөнхийлөн захирагч тооцоо судалгаа хийсэн байна;

3. Хийгдэх гэж байгаа хөрөнгө оруулалтын хүрэх үр дүнд, техник, эдийн засгийн үндэслэл, зардлын үр ашгийн тооцоо, УИХ-ын 2008 оны 13 дугаар тогтоолоор баталсан Мянганы хөгжлийн зорилтын хэд дэх шалгуур үзүүлэлтийн үр дүнд яаж хүрэх гэж байгааг заавар, аргачиллын дагуу боловсруулсан байна;

4. Монгол Улсыг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын объектын техник, эдийн засгийн үндэслэл, зураг, төсөв албан ёсоор батлагдсаны дараа холбогдох тооцооны хамтаар Сангийн яаманд ирүүлнэ;

5. Сангийн яамны төсвийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан нэгж

материалыг хянан үзэж нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг тодорхойлон, мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжид УИХ-аас баталсан Мянганы хөгжлийн зорилтод нөлөөлөх үр дүнг нарийвчлан тооцож Сангийн сайдад танилцуулсны дараа хөрөнгө оруулалтын жагсаалтад төсөвт өртөг, эхлэх, дуусах хугацаа, тухайн жилд санхүүжүүлэх мөнгөний дүнг оруулна;

6. Монгол Улсыг хөгжүүлэх сангаас барилга, байгууламжийн их засвар, өргөтгөлийн ажлыг санхүүжүүлэхгүй;

7. Дээрх шаардлага, зарчмыг хангаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг санхүүжүүлэх объектын жагсаалтад оруулахгүй. Нэг арга хэмжээг Улсын төсөв болон Монгол Улсыг хөгжүүлэх сан гэсэн хоёр эх үүсвэрээс зэрэгцүүлэн санхүүжүүлэхгүй байх зарчим баримтална;

8. Монгол Улсыг хөгжүүлэх санд өмнөх оны гүйцэтгэлээр төвлөрүүлсэн хөрөнгийг Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулийн 6.1-д заасан зориулалтаар хуваарилан тайлант жилийн дараагийн төсвийн жилд зарцуулах зарчим баримтална;

9. Хөрөнгө оруулалт болон хүүхэд, гэр бүлийг дэмжих хөрөнгийн хязгаарыг хатуу баримтлан санхүүжилтийн төлөвлөгөө хийнэ.

Хоёр. Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг төлөвлөхөд баримтлах тэргүүлэх чиглэл:

1. Боловсрол
-хүүхдээ зөв хүмүүжүүлж боловсрол олгох, тэдгээрийг боловсролоо байнга дээшлүүлэх чадвартай байлгах;

-хөдөөгийн малчин өрхийн 0-6 насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох ажлыг зохион байгуулах, 6 настай хүүхдийг сургуульд бүрэн хамруулж ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны тохилог орчинг бүрдүүлэх;

-дотуур байранд суух хүүхдийн тоог 2,1 дахин нэмэгдүүлэх;

-шаардлагатай аймаг, сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрыг шинээр барих ажлыг 2010 он гэхэд дуусгасан байх;

2. Эрүүл мэнд

-эрүүл мэндийн салбарын боловсон хүчний мэргэжлийн ур чадварыг орчин үеийн шаардлагад нийцүүлэх;

-эмчилгээ, оношилгоонд хийх үйл ажиллагааны чанарт ахиц гаргах;

-терийн өмчийн эмнэлгийн ажилтан бэлтгэх сургуулиудыг орчин үеийн сургалтын тоног төхөөрөмжөөр хангах;

-амаржих газар, нярайн төвүүдийг зориулалтын дагуу барьж байгуулан шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах;

-хөдөөгийн хүн амд үзүүлэх эмчилгээ үйлчилгээний чанарыг сайжруулж, аймаг дүүргүүдийн эмнэлгийн оношилгоо, эмчилгээний чадварыг бэхжүүлэх, технологийн шинэчлэл хийхэд түлхүү анхаарах.

3. Түлш, эрчим хүчний салбар

-эрчим хүчний эх үүсвэрт холбогдоогүй байгаа сумдыг байнгын эрчим хүчтэй болгох бодлого баримтлах;

-байгаль орчинд ээлтэй, өндөр үр ашигтай, шинэ техник, технологид тулгуурлан дулааны цахилгаан станц, цахилгаан дулааны шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөтгөх, шинэ эх үүсвэр барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх;

-нүүрс, хийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн нүүрснээс шимгэн түлш, шатдаг хий, кокс, химийн бүтээгдэхүүн гаргах техник, технологийг нэвтрүүлэхийг дэмжих.

4. Зам, тээврийн салбар

-олон улсын авто замын сүлжээнд нэгдсэн чиглэлүүдийн дагуух авто замыг тэргүүн ээлжинд барих;

-"Мянганы зам"-ын хэвтээ, босоо тэнхлэгүүдийн замыг барьж дуусгах;

-аймгийн төвүүдийг нийслэлтэй хатуу хүчилтэй замаар холбох;

-хөрш орнуудыг холбосон хоёр дахь төмөр замыг барихад дэмжлэг үзүүлэх.

5. Барилга, хот байгуулалт

-бусийн тулгуур төв, худалдааны болон эдийн засгийн чөлөөт бүсийн хотууд, аймгийн төвүүдэд цэвэр, бохир усны төвлөрсөн шугам, цэвэрлэх байгууламж барих,

-шинэ хорооллын дулааны шугамын хөрөнгө оруулалтын ажлыг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

-Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;

-гэр хорооллыг орон сууцжуулахад зориулсан дэд бүтцийг бий болгох зэрэг ажлыг санхүүжүүлэх.

6. Хүнс, хөдөө аж ахуй

-хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг дэмжих;

-хүнсний аюулгүй байдлыг олон улсын стандартын түвшинд хянан шинжлэх, баталгаажуулах чадвартай лабораториудыг байгуулах.

7. Бусад салбар

-газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах;

-атомын цахилгаан станц барих;

-ашигт малтмал боловсруулах үйлдвэр барих зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах зэрэг стратегийн ач холбогдол бүхий томоохон хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрүүдийг судлан үзэж дэмжлэг үзүүлэх.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 185

Улаанбаатар хот

Комиссын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"гишүүд" гэсэн хэсэгт "Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга" гэж нэмсүгэй.

"Комиссын бүрэлдэхүүн, журам батлах тухай" Засгийн газрын 2008 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 11 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД**

М.ЭНХБОЛД